



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА

Багийн ахлагч, Доктор (PhD), дэд профессор
Хот ба бүс нутаг төлөвлөлтийн судлаач
Хот ба бүс нутаг төлөвлөлтийн судлаач

Т.Намнан
Л. Эрдэнэпүрэв
Ц. Номин-Эрдэнэ

АГУУЛГА

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ.....	2
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА	2
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	4
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРОН НУТГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	10
БҮЛЭГ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	16
БҮЛЭГ 5. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	33
БҮЛЭГ 6. ЦОГЦОЛБОРЫН ХЭМЖЭЭНД ГАРАХ АЖЛЫН БАЙРНЫ ТООНЫ ТӨСӨӨЛӨЛ	43
БҮЛЭГ 7. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ КОНЦЕПЦ	49
БҮЛЭГ 8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТОЙМ ТООЦОО.....	90
БҮЛЭГ 9. ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНАЛ.....	100
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	106

Зургийн жагсаалт

Зураг 1. СБҮ-ийн салбарын бүртгэлтэй ААНБ - ын тоо, салбараар	23
Зураг 2. СБҮ -ийн салбарын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ - ын тоо, 2020 оны байдлаар	24
Зураг 3. СБҮ- ийн салбарын ажиллагчдын тоо, СБҮ - д хамаарах чиглэлээр, дүнгээр .	25
Зураг 4. СБҮ- ийн салбарын ажиллах хүчний нас, хүйсээр	25
Зураг 5. СБҮ - ийн салбарын ажиллагчдын тоо, нийт дүнгээр	26
Зураг 6. Ажил эрхэлж буй иргэд болон ажилгүй иргэдийн тоо 2022 - 2045 он	45
Зураг 7. Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор нэгдсэн ерөнхий төлөвлөгөө	50
Зураг 8. Кино хотхоны ерөнхий төлөвлөгөө	52
Зураг 9. Ерөнхий төлөвлөгөө	52
Зураг 10. Ерөнхий төлөвлөгөө	53
Зураг 11. Ерөнхий төлөвлөгөө	53
Зураг 12. 1.1 Оффис	54
Зураг 13. 1.2 Кино театр	54
Зураг 14. 1.3 Зочид буудал	55
Зураг 15. 1.4 Оффис, худалдаа үйлчилгээний төв	55
Зураг 16. 1.5 Сургалтын байгууллага	56
Зураг 17. 1.6 Кино урлагийн музей	56
Зураг 18. 1.7 Кино зураг авалтын павилонууд	57
Зураг 19. Дизайн, урлагийн хотхоны ерөнхий төлөвлөгөө	58
Зураг 20. 1. Дизайны төв	58
Зураг 21. 2. Гар урлал, үйлдвэрлэл төв	59
Зураг 22. 3. Уран зургийн галерей, үзэсгэлэнгийн төв	59
Зураг 23. 4. Дизайн молл	60
Зураг 24. Дизайн молл хувилбар 2	60
Зураг 25. Судалгаа, хөгжүүлэлтийн хотхоны ерөнхий төлөвлөгөө	62
Зураг 26. 1. Их сургууль, зочид буудал	62
Зураг 27. Их сургууль, зочид буудал хувилбар 2	63
Зураг 28. 2. Үйлчилгээний барилга ба спорт цогцолбор	63
Зураг 29. 3. Эрдэм судлал	64
Зураг 30. Эрдэм судлал хувилбар 2	64
Зураг 31. Монгол ёс заншил, өв уламжлал, үндэсний үнэт зүйл, Соёл төвийн ерөнхий төлөвлөгөө	65
Зураг 32. Монгол ёс заншил, өв уламжлал, үндэсний үнэт зүйл, Соёл төвийн ерөнхий төлөвлөгөө	66
Зураг 33. Монгол ёс заншил, өв уламжлал, үндэсний үнэт зүйл, Соёл төвийн ерөнхий төлөвлөгөө	66
Зураг 34. 1. Өв соёл, уламжлалын газар	67
Зураг 35. 2. Уламжлалт тоглоом наадгай, угсаатны зүй, түүхийн танилцуулгын төв	67
Зураг 36. 3. Оффис	68
Зураг 37. Тайзны урлаг, хөгжмийн төвийн ерөнхий төлөвлөгөө	69
Зураг 38. 1. Тайзны урлагийн төв	69
Зураг 39. 2. Хөгжмийн урлагийн төв	70
Зураг 40. Контент үйлдвэрлэлийн хотхон	71
Зураг 41. 1. Оффис үйлчилгээний барилга	71

Зураг 42. 2. Контент үйлдвэрлэлийн төв	72
Зураг 43. 3. Ресторан	72
Зураг 44. А1.Эмнэлэг	73
Зураг 45. А2.Спорт цогцолбор.....	74
Зураг 46. А3. Аюулгүй ажиллагааны байр.....	74
Зураг 47. Б1. Дулаан зогсоол	75
Зураг 48.Зогсоол.....	75
Зураг 49. Зам талбай, дэд бүтэц.....	76
Зураг 50. Мини Монголын ерөнхий төлөвлөгөө	79
Зураг 51. 1. Цирк хувилбар 1	79
Зураг 52. 2. Аялалын төв	80
Зураг 53. 3. Үзэсгэлэнгийн төв хувилбар 1.....	80
Зураг 54. 4. Оффис хувилбар 1.....	81
Зураг 55. 4. Оффис хувилбар 2.....	81
Зураг 56. 5. Үйлчилгээний газар	82
Зураг 57. 6. Худалдааны төв.....	83
Зураг 58. 7. Буудал.....	83
Зураг 59. 8. Ресторан	82
Зураг 60. 9.Миний Монгол /Mini Mongolia/	83
Зураг 61. Нүүдэлчин ахуй цогцолбор хувилбар 1	84
Зураг 62. Нүүдэлчин ахуй цогцолбор хувилбар 2	84
Зураг 63. Нийтийн тээвэр терминал.....	85
Зураг 64. Ариутгах татуурга	86
Зураг 65. Цэвэр ус хангамжийн зураглал.....	87
Зураг 66. Цахилгаан хангамж.....	88
Зураг 67. Дулаан хангамжийн зураглал	89

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Соёл урлагийн салбарын хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд.....	7
Хүснэгт 2. Олон улсын бүтээлч байдлын үзүүлэлтүүдийн харьцуулалт	19
Хүснэгт 3. Улс орнуудын зах зээлийг хөгжүүлэх бодлогын чиглэлүүд.....	21
Хүснэгт 4. Глобал инновацийн индекс	21
Хүснэгт 5. СБҮ-ийн салбарын бүртгэлтэй ААНБ - ын тоо, 2020 оны байдлаар.....	22
Хүснэгт 6. СБҮ -ийн салбарын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ – ын тоо, 2020 оны байдлаар.....	23
Хүснэгт 7. СБҮ- ийн салбарын ажиллагчдын тоо, СБҮ–д хамаарах чиглэлээр	24
Хүснэгт 8. СБҮ - ийн салбарын ажиллагчдын тоо, салбараар	25
Хүснэгт 9. СБҮ - ийн салбарын ажиллагчдын тоо, салбар, хүйсээр, 2020 оны байдлаар	27
Хүснэгт 10. ХБ ажиллагчдын тоо, жилээр.....	28
Хүснэгт 11. ХБ ажиллагчдын тоо, ажил мэргэжлээр, 2020 оны байдлаар.....	28
Хүснэгт 12. СБҮ - ийн салбарын төгсөгчдын тоо, салбараар, 2019-2020 оны байдлаар	29
Хүснэгт 13. Их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн хөтөлбөрийн тоо.....	29
Хүснэгт 14. СБҮ - ийн салбарын төгсөгчдийн тоо, хөтөлбөрийн чиглэлээр, 2019-2020	30
Хүснэгт 15. Япон улсын салбаруудын тодорхойлолт	37
Хүснэгт 16. Хамрах хүрээ	38
Хүснэгт 17. Монгол Улсын харьяат хөдөлмөрийн насны хүн ам 2015 – 2045 он /1000 хүн ам/.....	43
Хүснэгт 18. ЭЗИХА, ажил эрхэлж буй болон ажил эрхлээгүй иргэдийн тоо, 2010 он – 2021 он, 1000 хүн ам	44
Хүснэгт 19. ЭЗИХА, ажил эрхэлж буй болон ажил эрхлээгүй иргэдийн тооны таамаглал 2022 он - 2045 он, 1000 хүн ам	44
Хүснэгт 20. Соёл салбарт ажиллагчдын тоо, 2010 он - 2021 он	45
Хүснэгт 21. Соёл салбарт ажиллагчдын тооны таамаглал, 2022 он - 2045 он.....	46
Хүснэгт 22. Цогцолборын хэмжээнд бий болох ажлын байрны тоо	46



1. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. Хууль эрх зүйн орчин
2. Олон улсын туршлага
3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахад шаардлагатай суурь хүчин зүйлүүдийг нөөц, чадавхад үндэслэн тодорхойлно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгааны ажлын зорилго: Энэхүү ажил нь Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарт уран бүтээл туурвиж, үйлдвэрлэл эрхлэгчдийг орон зайн хувьд нэг дор цугларч хамтран ажиллах, суралцах, хөгжих бололцоогоор хангаж, өртөг зардал хэмнэхийн зэрэгцээ гадаадын томоохон студи, продакшн, хөрөнгө оруулагчдыг татах томоохон логистик төв байгуулах суурь судалгааг гүйцэтгэх зорилготой.

Судалгааны ажлын хамрах хүрээ: Судалгааны ажил нь дараах хүрээг хамарна. Үүнд:

- Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахад шаардлагатай суурь хүчин зүйлүүдийг нөөц, чадавхад үндэслэн тодорхойлно.
- Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын хөрөнгө оруулалтын ашигтай загварыг тодорхойлно.
- Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын удирдлагын зүй зохистой, үр дүнтэй системийг тодорхойлно.
- Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын нийт хэмжээ, хүчин чадлын тооцоог тодорхойлно.
- Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборт байрших объектуудыг тодорхойлж, байршлын ерөнхий схем боловсруулна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн бизнес эрхлэгч, бүтээн туурвигч, үйлчлүүлэгч, худалдан авагчдыг төвлөрүүлэх логистик сүлжээ бүхий цогцолборыг байгуулснаар өртөг зардал буурч эдийн засгийн үр өгөөж нэмэгдэж, тогтвортой хөгжих үндэс суурь тавигдана. Түүнчлэн цогцолборт үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ, уран бүтээлчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Монгол Улсыг гадаадад сурталчлах, экспортыг нэмэгдүүлэх өргөн боломжийг бий болгох зэрэг цогцолборыг түшиглэн гарааны бизнес, инновацын экосистембүрдэхээс гадна нийгмийн соён гэгээрэлд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах боломжтой юм. Төслийн хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага:

- Манай улсын хувьд соёл, урлагийн салбарыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар аймаг бүр уламжлалт өв, Соёл өвөрмөц хэв шинжийг хадгалсан бүтээлч орчныг бүрдүүлэх боломж байгаа бөгөөд тэр дундаа Соёл аялал жуулчлалаар дамжуулан хөгжүүлэх боломжтой байна;
- Дэлхий дахиныг хамарсан даяаршлын үйл явцын эрчимжилт, технологийн хурдацтай хөгжил нь хүн ам Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвхөн соёл, урлагийн байгууллагаас бус, телевиз, интернэт виртуал орчин гэх мэт олон эхүүсвэрээс хүлээн авах шаардлагатай байна;
- Хүн амын Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх эрэлт нэмэгдэхийн сацуу, үзэгчдээс тавих шаардлага, үнэлэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна;
- Хүн амын соёл, урлагийн боловсролын эрэлт, аж ахуйн нэгж арга хэмжээнд ач холбогдол өгөх хандлага нэмэгдэж байгаа тул байгууллагууд ажилчдын чөлөөт цагт чиглэгдсэн зорилтот соёл, урлагийн салбарт оюуны өмчийн талаарх ойлголт дутмаг байна;

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

- Орчин үед даяаршлын нөлөөгөөр Монголд өрнө, дорнын явдал газар авч байгаагийн зэрэгцээгээр хотжилт, түүнээс нийтийн урлаг хүч түрэн нэвтэрч, түүнд залуу үе татагдан дагах уусган өөрчлөх хандлагыг бий болгох шаардлагатай байна;

Эдийн засгийн эрэлт, хэрэгцээ, шаардлага:

- Бүтээлч үйлдвэрлэл нь дэлхийн улс орнуудын хувьд тэргүүлэх салбар болж байгаа тул олон улсад өрсөлдөх давуу байдлыг олж авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай;
- Улс төрөөс хамааралтай өрсөлдөх чадварыг бууруулж, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх байдлыг бууруулах шаардлагатай;
- Улсын төсвөөс төрийн өмчийн соёл, урлагийн байгууллагуудад тодорхой хэмжээний санхүүжилт өгч байгаа боловч санхүүгийн эрх мэдлийг бүрэн олгоогүй нь хөгжилтэй орнуудын түвшинд хөгжүүлэх асуудлыг бие даан шийдвэрлэж байгаа нь асуудлыг үүсгэж байна;
- Соёл, урлагийн салбарын хөгжлийн бодлого, стратегийг боловсруулалт байхгүйгээс үүдэн Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна;
- Соёл, урлагийн салбарын хөгжлийн урт хугацааны бодлого стратегид тулгуурлан нэгдмэл, зохион байгуулалтаар гадаад зах зээлд өрсөлдөх давуу байдлыг бүрдүүлэх шаардлагатай;
- Соёл дэлхийн соёлд эзлэх байр суурийг бэхжүүлж, монгол брэндийг олон улсын түвшинд хөгжүүлэх шаардлагатай;
- Цогцолборыг түшиглэн гарааны бизнес, инновацын экосистем бүрдэхээс гадна нийгмийн соёл гэгээрэлд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Дэд бүтцийн хэрэгцээ шаардлага:

- Шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх мэдээллийн дэвшилтэд технологийн хайгуулыг тогтмол хийж, шинэ техник технологийг соёл, урлагийн байгууллагууд үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай байна;
- Дэлхий дахинд бий болсон шинжлэх ухаан, технологийн ололтыг олж авах, хэрэгжүүлэх бүх талын боломж хангагдаагүй тул энэ талаар тусгайлсан хөтөлбөр, хөрөнгө оруулалт, дэмжлэг, тусламжийг төрийн зүгээс хангах шаардлагатай;
- Соёл, урлагийн салбарын инновацын соёл төлөвшөөгүй байгаа нь уламжлалт арга барилаар асуудалд хандах хандлагатай байгааг өөрчлөх шаардлагатай;
- Орчин үеийн дэвшилтэт технологиор дамжуулан контент менежмент хийх, сошиал маркетинг хэрэгжүүлэх талаар ойлголт муу байгаа нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагыг бий болгож байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчны одоогийн баримталж байгаа баримт бичгүүдийг авч үзлээ.

Бодлогын баримт бичиг:

“АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-д тусгагдсан: Зорилго 4. “ЭДИЙН ЗАСАГ”:

- Зорилт 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.
- 4.2.25 Бүтээлч үйлдвэрлэл болон мэдээлэл технологийн үйлдвэрийг эдийн засгийн бүтцэд тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлнэ.
- 4.2.26 Бүтээлч аж үйлдвэрийг дэмжих институт, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэхжүүлнэ.
- 4.2.27 Бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг өндөр хөгжилтэй оронд бэлтгэж, энэ чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.
- 4.2.28 Бүтээлч үйлдвэрлэлийн салбарын дотоод төрөлжилтийг хангах бодлогод тулгуурлан гадаад зах зээлд байр сууриа олсон брэндүүдийг бий болгоно.
- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан:
- 4.2.4-т “Бүтээлч үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурь тавигдсан байна”.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн:

- 2.6-д “Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, Соёл бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно”;
- 2.6.2-т “Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ”;
- 2.6.2.4-т “Соёл бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ,
- 2.6.3-т “Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инноваци шингэсэн Соёл бүтээлч үйлдвэрлэл-инновацийн салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ”;
- 2.6.3.3-т “Үндэсний агуулгатай инноваци шингэсэн Соёл бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, Соёл аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна”.

Хууль:

- Кино урлагийг дэмжих тухай хууль
- Номын сангийн тухай хууль
- Соёл өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль
- Соёл тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

Олон улсын гэрээ, конвенц:

- Зэвсэгт мөргөлдөөний үед Соёл өвийг хамгаалах тухай Гаалийн конвенц, 1954
- "Зохиогчийн эрхийн тухай дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ"
- "Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай бернийн конвенц"
- Соёл илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай ЮНЕСКО-ийн конвенц
- Соёл биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенц
- Соёл үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-ийн конвенц
- Дэлхийн Соёл болон байгалийн өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенц

Улсын Их Хурлын тогтоол:

- Соёл хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /1996.04.11-ний 21дүгээр тогтоол/
- Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай /Жагсаалтад нэмэлт оруулах тухай/
- Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал
- Төрөөс Соёл талаар баримтлах бодлого батлах тухай /2012.05.22-ны 52 дугаар тогтоол/
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /2016.09.09-ний 45 дугаар тогтоол/
- Түүх, Соёл дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Дүрэм, журам:

- Хүүхдийн номын ордны дүрэм
- Монгол улсын үндэсний номын сангийн дүрэм
- Төрийн хэлний зөвлөлийн дүрэм
- Соёл, урлагийн дэмжих сангийн дүрэм
- Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар
- Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэм
- Улс, аймгийн чанартай музейн дүрэм
- Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм
- Дүүргийн Соёл ордны үлгэрчилсэн дүрэм
- Сумын Соёл төвийн үлгэрчилсэн дүрэм
- Эрдмийн театр чуулгын үлгэрчилсэн дүрэм
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм
- Улс, орон нутгийн музейн дүрэм
- Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм
- Аймаг, нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм
- Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам
- Хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам
- Гадаадын байгууллага, иргэдэд кино зураг авах зөвшөөрөл олгох журам

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

- Олон улсын өсвөрийн шилдэг хөгжимчин бүжигчин, циркийн жүжигчин шалгаруулах уралдаанд оролцох сурагчид, мэргэжлийн багшид санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам
- Хэвлэх Соёл өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам
- Киноны шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам
- Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам
- Соёл ажилтныг тэтгэвэрт гарахад нь тэтгэлэг олгох журам
- Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үнэлэх журам
- Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам
- Шилдэг уран бүтээлч шалгаруулах журам
- Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам
- Соёл ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, санхүүжүүлэх журам
- Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож онцгой амжилт гаргасан Соёл ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох журам

Эрх зүйн онцгой зохицуулалт, тусгайлсан дэмжлэг:

- Кино урлагийг дэмжих тухай хууль
- Соёл, урлагийн сан байгуулах тухай
- Засгийн газраас Эдийн засгийн дараах салбаруудыг тэргүүлэх чиглэл болгон, бодлогоор онцгойлон дэмжихээ зарласан.
 - Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл
 - Хүнс, хөдөө аж ахуйн салбар
 - Аялал жуулчлалын салбар
 - Бүтээлч эдийн засгийн салбар
 - Мэдээллийн технологийн салбар
 - Эрчим хүч, тээвэр логистик
- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ түүх, соёл, зан заншил, өв уламжлал, ахуй амьдрал зэргийг харуулсан Соёл аливаа бүтээлийг гадаад зах зээлд гарахад нь хууль эрх зүйн таатай орчин, татварын бодлого гээд бүх талаар дэмжихээ илэрхийлсэн. Мөн Монгол Улс үндэсний өв баялаг соёлоо эдийн засгийн эргэлтэд оруулж, Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжсөн салбарыг бий болгож, бүтээлч, чадварлаг боловсон хүчний оюуны бүтээлээр дэлхийд өрсөлдөх нь хөгжлийн гарц болохыг онцолсон.

Бусад, төсөл хөтөлбөрүүдтэй уялдах уялдаа:

А. Соёл, урлагийн салбарт хэрэгжиж буй томоохон төслүүд:

Санхүүжилтийн эх үүсвэр болон хэсэгчлэн шийдвэрлэгдсэн, төсөл арга хэмжээ:

- Байгалийн түүхийн музей
- Үндэсний урлагийн их театр
- "Чингис хаан" хаад язгууртны музей

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт:

- Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл
- Үндэсний урлагийн их театрт тайз, дуу авианы тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл
- Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга
- Улсын драмын эрдмийн театрын барилга
- Төв номын сангийн барилгыг хүчитгэж шинэчлэх

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт:

- Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор
- Хүүхдийн Соёл өв, хөгжлийн цогцолбор /хүүхдийн Соёл өв, уламжлалын төв, театр, номын сан, кино театр, чөлөөт цагийн төв, цэцэрлэгт хүрээлэн г.м. (монгол үндэсний диснейлэнд)
- Соёл яамны барилга
- Улсын драмын эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл
- Хүүхэд, залуучуудын театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл
- Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр
- Хөвсгөл нуурыг түшиглэсэн Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв
- Соёмбо музей байгуулах төсөл

Б. Соёл, урлагийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд:

Хүснэгт 1. Соёл урлагийн салбарын хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд

№	Үндэсний хөтөлбөрүүд	Хөтөлбөрийн зорилго	Хугацаа
1	Монгол уран бүтээл	Монгол уран бүтээлийг радио, телевиз, киноны зах зээл, цахим орчинд нэмэгдүүлэх замаар хойч үедээ уламжлалт соёл, түүх, зан заншлыг өвлүүлэн уламжлуулах, өв соёлоо хадгалж, хамгаалах, үндэсний соёлоор бахархах үзлээр хүмүүжүүлэх, дэлхийн зах зээлд үндэсний соёлыг сурталчлах, монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	2015-2025
2	Соёл үйлдвэрлэл	Үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, Соёл үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол Соёл нөлөөг дэлхий нийтэд сурталчлан таниулах	2016-2020
3	Соёл баримтлах өвийг хамгаалах	Соёл баримтат өвийн үндэсний хэмжээний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, баримтат өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлах, хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, сурталчлах	2018-2022
4	Сонгодог урлаг III	Сонгодог урлагийн нийгэм, эдийн засгийн	2018-2023

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

		хөгжилд үзүүлэх эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх, салбар хоорондын үр дүнд суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлж сонгодог урлагийн тогтвортой хөгжлийг хангах	
5	Соёл биет бус өвийг хамгаалах	Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа монгол угсаатны олон бүлгийн Соёл биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх	2019-2023
6	Чулуун Соёл өв	Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байгаа түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой хадна зураг, бичээс, буган чулуун хөшөө, хүн чулуун хөшөө, тамга тэмдэг, бичээс бүхий хөш, амьтны дүрст чулуун дурсгал, зураг, тамга бүхий хавтан чулуун дурсгалууд зэрэг чулуун Соёл өвийг бүртгэн баримтжуулах, судалж, шинжлэх, хадгалж хамгаалж, мэргэн засварлах, сурталчлан таниулах, сэргээн засварлах, сурталчлан таниулах, зохистой ашиглах замаар чулуун Соёл өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, хамгаалах	2019-2024

В. Соёл бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх байршил буюу Төв аймагт хэрэгжих томоохон төслүүдийн жагсаалт:

Санхүүжилтийн эх үүсвэр бүрэн болон хэсэгчлэн шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт:

- Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл
- Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл /Азийн авто замын сүлжээний АН-3 - Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто замын шинэчлэл, Дархан-Алтанбулаг чиглэлийн автозамын засвар арчлалт, Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км замын их засварын ажил/
- Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих
- Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл /Концессын эргэн төлөлт/
- 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл
- Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто зам

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт:

- Манзушир хийдийн соёл, шашин, аялал жуулчлалын цогцолбор
- Богдхан төмөр зам төсөл
- Налайх-Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл
- 10 аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, түгээх сүлжээг шинэчлэх, хэрэгцээний халуун усны сүлжээг байгуулах

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

- Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах төсөл
- Халдварт өвчин судлалын үндэсний төв-II байгуулах
- Залуус I орон сууцны хорооллын зураг төсөл, инженерийн шугам сүлжээ, холбогдох барилга байгууламж, автозамын угсралтын ажил
- Ээрэх үйлдвэр байгуулах төсөл
- Багануур-Чойрын 220кВ-ын 2 хэлхээ 200 км урттай өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл
- Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 518 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц
- Богдхан төмөр зам төсөл
- Улаанбаатар - Мандалговь - Даланзадгад чиглэлийн авто замыг шинэчлэн өргөтгөх
- Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт 100 км хатуу хучилттай автозам төсөл /Орхоны гүүр - Төв аймгийн Жаргалант/
- Баянхонгор, Говь-Алтай, Төв аймаг, нийслэлийн Багануур дүүргийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, өргөтгөх, шинээр барих төсөл
- Шинэ Зуунмод хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулах, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх
- Майдар эко хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний иж бүрэн зураг төсөл боловсруулах, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх

Шинэ Зуун мод хот: Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй агаар, ус, хөрсний бохирдол, сөрөг нөлөөг бууруулах, олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, тээвэр логистик, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн зэрэглэлтэй “Шинэ Зуунмод” хотыг шинээр байгуулах шийдвэр гарсан.

Майдар хот төслийн танилцуулга: УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоолоор Шинэ, Зуунмод, Майдар хот байгуулах тухай шийдвэрлэсэн. Засгийн газрын 2018 оны 273 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 12000 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Эко Майдар хот байгуулах төсөл нь хувийн хэвшлийн санаачилгаар боловсруулагдаж байгаа бөгөөд энэ төслийн хүрээнд Майдар хот төсөл хэрэгжүүлэх газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийхэд шаардлагатай 167.0 сая төгрөгийн санхүүжилтийг улсын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхээр Засгийн газраас шийдвэрлэсэн. БХБЯ-аас хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулах ажлыг зохион байгуулж, баталгаажуулах шатанд явж байна. 2022-2024 онд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлуудыг үе шаттайгаар боловсруулна.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРОН НУТГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Уг судалгаагаар Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг хөгжлийн түвшнийг илэрхийлэх гол шалгуур үзүүлэлтүүдийг авч үзлээ.

А. Төв аймгийн хөгжлийн өнөөгийн байдал:

Төв аймаг нь 1923 оны 10-р сарын 19-ний Засгийн газрын 38-р тогтоолоор Халхын дөрвөн аймгийг хаадын нэрээр нэрлэж байсныг өөрчилж уулсын нэрээр нэрлэх болсноор Түшээт хан аймаг нь Богд хан уулын аймаг гэж нэрлэгдэх болсон. Богд хан уулын аймаг нь Онгийн голоор савлан зүүн талаараа Хэнтий нуруу хүрч, хойд талаараа ОХУ, өмнөд талаараа Хятад улсын хил тулж Монгол улсын нутгийн бараг дөрөвний нэгийг хамарсан нутагтай байсан.

Богд хан уулын аймгийг 61617 хүн ам, 502776 толгой мал, 21 хошуу, 82 сум, 1227 арван гэрийн захиргаатайгаар зохион байгуулан аймгийн төвийг Лүн сумын нутагт Өвөр долоод гэдэг газар том, жижиг 7 гэртэйгээр байгуулжээ. 1933 онд 36 сум, 312 баг, 22328 өрх, 80.5 мян хүн ам, 2391700 толгой малтай байжээ. Төв аймгийн төвийг Улаанбаатар хотноо нүүлгэн төвлөрүүлж, 1942 он хүртэл нийслэл хотод ажиллаж байв.

1934 оны 8-р сарын 1-ний өдрийн аймгийн 11-р хурлын материалд Төв аймгийн сумын нэрсийн жагсаалтад Дашинчилэн, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн, Мандал, Бүрэгхангай, Цагаандэлгэр, Сайханбаян, Эрдэнэдалай, Цагаан-Овоо зэрэг одоогийн Сэлэнгэ, Булган, Дундговь аймгийн сумдын нэр бичигдсэн байна. Авдарбаян, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баянбараат, Баянзүрх, Баянцагаан, Баян-Өлзийт, Баянцогт, Бүрэн, Бор-Өндөр, Галтбадрах, Говьсүмбэр, Нялга, Мөнгөнморьт, Лүн, Өнжүүл, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант гэсэн 22 сумтай үлджээ.

Дэлгэрхаан сум дээрх 1941.12.11 ний өдрийн 81-р тогтоолоор Өвөрхангай аймагт шилжсэн боловч БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1944.03.31-ний өдрийн 19-р тогтоолоор Төв аймагт эргүүлэн шилжүүлжээ.



Төв аймгийг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн хугацаанд баримтлан ажиллах чиглэл:

1. “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” бүлгийн хүрээнд: Үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн монгол хүнийг төлөвшүүлэх, улс үндэстнийхээ болон орон нутгийнхаа оюуны биет ба биет бус өв соёл, үнэт зүйлс, уламжлалт зан заншлыг өвлөх, хадгалах, хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, нийгэмд Соёл үнэт зүйлийг бий болгоход чиглүүлэх, Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшүүлэх;

2. “Хүний хөгжил” бүлгийн хүрээнд: Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог чанаржуулан, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах, Эхийн эндэгдлийн түвшинг 100.000 амьд төрөлтөд тэглэх, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг бууруулах, улмаар дундаж наслалтыг 74.0-д хүргэх зорилт, Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагыг хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж, эрүүл аюулгүй, ээлтэй орчин, чанартай, хүртээмжтэй үйлчилгээг бий болгох, Хүүхэд, гэр бүл, залуучуудад суурилсан нийгмийн эерэг өөрчлөлтийг бий болгож, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэн өв тэгш хүмүүжилтэй хүүхэд, залуучууд, гэр бүлийг төлөвшүүлэх;

3. “Амьдралын чанар ба дундаж давхарга” бүлгийн хүрээнд: Иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулан, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар өрхөд нийгмийн хөгжлийн цогц үйлчилгээг үзүүлж ядуурлын түвшинг 2020 оны түвшнээс 2.5 пунктээр бууруулж 18.0 хувьд хүргэх, ажилгүйдлийн түвшинг 0.5 пунктээр бууруулж 3.6 хувьд хүргэх;

4. “Эдийн засаг” бүлгийн хүрээнд: 2 Өсөлттэй өгөөжтэй эдийн засагтай аймаг болох, Нийлүүлэгч аймгаас Үйлдвэрлэгч аймаг болох гол зорилт бөгөөд тус бүлгийн хүрээнд:

- Эдийн засгийн дундаж өсөлтийг 6-12.0 хувь өсгөх;
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх;
- Эдийн засгийн бүтцийг сайжруулах;

5. “Засаглал” бүлгийн хүрээнд: Төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг хангасан удирдлага зохион байгуулалтын тогтолцоог сайжруулан, төрийн үйлчилгээг цахимжуулж, тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй, чадварлаг төрийн албыг төлөвшүүлэн, гадаад харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх;


6. Ногоон хөгжил бүлгийн хүрээнд: Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлж, байгаль орчны даац чадамжид суурилж, хүний үйл ажиллагаанаас хамааралтай доройтлыг хязгаарлан зүй зохистой ашиглах нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагааг, нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлэхээр, Хүн амд амьдрах орчны зөв дадал төлөвшүүлж хүрээлэн буй орчны чанарыг сайжруулах, Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах;

7. Амар тайван, аюулгүй нийгэм бүлгийн хүрээнд: Амар тайван аюулгүй орчин, нийгмийг бий болгоход төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хяналт, хамтын ажиллагааг өргөжүүлж, хууль сахиулах болон тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэн, амьдрах орчны эрсдэлт

нөхцөлийг бууруулах замаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

8. Бүс, орон нутгийн хөгжил бүлгийн хүрээнд: Олон улсын нисэх онгоцны буудал байгуулагдсан давуу тал болох эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, түүнийг хууль эрх зүйн хувьд баталгаажуулах, бүсийн хөгжлийг даган бий болох их бүтээн байгуулалтын бэлтгэлийг хангаж суурь дэд бүтцийн ажлуудыг хийх, бүх сумдыг төвлөрсөн халаалттай, цэвэр бохир усны систем бүхий нийтийн аж ахуйн цогц инженерийн шугам сүлжээг хөгжүүлэх, зарим сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай автозамаар холбох, сум, орон нутгийн нийгмийн болон төрийн үйлчилгээний барилга байгууламжийг барих, засварлах ажлуудыг хийж иргэдийг нутаг орондоо ая тухтай, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах зэргээр “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн бүтцийн дагуу 8 бүлэг, 8 зорилгын хүрээнд 37 зорилт, 178 үйл ажиллагаа, 163 шалгуур үзүүлэлттэй батлав.

Б. Төсөл хэрэгжих байршлын онцлог /Төв аймаг Сэргэлэн сум/:



Газар зүй, байршлын онцлог: Далайн түвшнээс дээш дунджаар 1200-1500 м өргөгдсөн. Хэнтийн нуруу, Заамарын нуруу, Зоргол хайрхан, Хустайн нуруу зэрэг уулархаг гадаргуутай. Асралт хайрхан (2800 м), Богд хан, Батхаан зэрэг уулс бий. Нутаг дэвсгэрийн 16.4 хувийг ой мод, 36.5 хувийг хээрийн бүс эзэлдэг. Газар зүйн байршлаар Хангай, Хэнтийн уулархаг, Дорно Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

Цаг уурын нөхцөл: Хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй, 1 дүгээр сарын дундаж температур -27°C , 7 дугаар сарын дундаж температур $+25^{\circ}\text{C}$, жилийн дундаж салхины хурд 6-8 м/с, жилийн хур тунадасны нийлбэр 250-350 мм байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Газар нэгдмэл сангийн ангилал: Газар нутаг: Нийт газар нутгийн хэмжээ 3865,7 га.

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	36446,75	91.8
Ойн сан бүхий газар	4975,80	1.27
Усан сан бүхий газар	309	0.08
Тусгай хэрэгцээний газар	18201.8	4.71
Тосгон, суурингийн газар	5172.76	1.25
Дэд бүтцийн газар	3448.9	0.89

Шилжилт хөдөлгөөн: Тус сум нь Төв аймагтай хаяа нийлэн оршдог нийт хүн амын 46 хувь нь сумын төвд амьдардаг. Сумын хүн амын 60 хувь нь залуу болон дунд насныхан, 25 хувь нь хүүхэд, 15 хувь нь хөгшид байна.

Нийгмийн үйлчилгээний, барилга байгууламж:

№	Барилга, байгууламж	Нэгж	Тоо
1	Сургуулийн дотуур байр	Ор	20
2	Цэцэрлэг	Хүүхэд	120
3	Эмнэлэг	Ор	6
4	Спорт заал	Тоо	1
5	Биеийн тамирын талбай	Тоо	1
6	Соёл төв	Тоо	1
7	Номын сан	Суудал	35
8	Банк	Тоо	1
9	Халуун ус	Тоо	1

Ажилгүйдэл, ядуурал: Суманд бүртгэлтэй ажилгүй иргэд 21 байна. Нийт ажилгүй иргэдийн 40 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 10 хувийг дээд, 4 хувийг тусгай дунд, 64 хувийг бүрэн дунд, 16 хувийг бүрэн бус дунд, 6 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна.

Хот байгуулалт газрын харилцаа: Сэргэлэн сумын төв нь Засаг захиргаа-хөдөө аж ахуй-үйлчилгээний үүрэг давамгайлсан тосгон юм. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2009 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн боловсруулж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. Сумын төвийн суурьшлын бүс хүн амын механик өсөлтөөс шалтгаалан сүүлийн 4 жилийн хугацаанд 250 га-аар нэмэгдсэн.

Хөдөө аж ахуй газар	354875 га
Хот тосгон бусад суурин газар	4832 га
Зам шугам сүлжээний газар	3440 га
Ойн сан бүхий газар	4910 га
Усан сан бүхий газар	309 га
Улсын тусгай хэрэгцээний газар	18208 га

Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Өнөөгийн байдлаар иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нийт 406иргэн газар өмчилж, иргэн ААН, 299,2 га газрыг ашиглаж, 185,03 га газрыг эзэмшиж байна.Хадлангийн 2892 га, тариалангийн 3840,6 га газар байна.

Сумын онцлог: Улаанбаатараас 54 километрийн зайд, Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хөшигтийн хөндийд 3600 метр урт нислэгийн талбай бүхий шинэ онгоцны буудал барьж байгуулж байна. Шинэ нисэх онгоцны буудал 2016 оны аравдугаар сар гэхэд үйл ажиллагаагаа эхлүүлэхээр зэхэж байна. Шинэ онгоцны буудал нь жилд гурван сая зорчигч хүлээн авах хүчин чадалтай байх бөгөөд цаашид өргөтгөх боломжтойгоор төлөвлөлт хийжээ. Мөн 100 мянган оршин суугчтай дагуул хотын бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлэх юм. Мөн манай суманд “Их майдар сан” төрийн бус байгууллагаас Монгол улсын аялал жуулчлал, шашин Соёл хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах “ИХ МАЙДАР” цогцолбор төслийг боловсруулж Өгөөмрийн аманд Зүрх толгойг сонгон байгуулахаар ажлаа эхлээд байна. Их Майдар төслийн хүрээнд шашин Соёл өвөрмөц хэв шинжийг агуулсан, хүүхэд залуучууд чөлөөт цагаа байгальд ээлтэй, эрүүл орчинд зөв боловсон өнгөрүүлэх, соён гэгээрэх, амралт чөлөөт цагийн цэцэрлэгт хүрээлэн бүхий үзвэр үйлчилгээний цогцолбор байгуулагдах юм. Уг цогцолбор Улаанбаатар хотоос 50 км зайтай Богд хан уулын энгэрт орших бөгөөд нийт 108 га газрыг хамруулан бүтээх юм. Энэхүү цогцолбор төслийн эхний үе шатанд Их Майдар бурханы 54 м өндөр бодьсатва дүр, 108 м өндөр Зарлиг увдисын суваргын хамт босгох бүтээн байгуулалтаар эхлээд байна. Энэхүү суварга нь дэлхийд бүтээгдсэн хамгийн өндөр суваргуудын нэг болох юм. Цогцолборын онцлог нь бурхан багшийн Ирээдүй цагийн дүр болох Майдар бурхныг Өндөр гэгээн Занабазарын урласан тигээр бүтээж буй бөгөөд дэлхийд томоохонд тооцогдох бүтээн байгуулалт болж байгаагаар онцлог юм.

Салхины нөөц:



Ургамал, амьтан: Төв аймгийн уулсад Хуш, Шинэс, Улиас, Бургас, Нарс, Яргай, зэрэг янз бүрийн модтой . Мөн Өрөл , Мойл, Үхрийн нүд, Нохойн хошуу , зэрэг жимс Сонгино Хөмөл Мангир Халиар Чихэр өвс мэтийн ховор болон Дэгд Таван салаа Тарваган

шийр Алтан гагнуур гэх мэт эмийн ургамал ургадаг. Мөн Буга Согоо Хандгай Аргаль Угалз Хойлог Хун зэрэг 16 зүйлийн дархан цаазат амьтдаас гадна Хэрэм Гарвага Үнэг Хярс Гахай Шилүүс Баавгай зэрэг агнуурын ач холбогдолтой 30 гаруй төрлийн араатан жигүүртэн байдаг.

Хүн төрөлхтний түүхэн хөгжил нь уг чанартаа Соёл хөгжлийн үйл явц байдаг билээ. Иймээс Соёл судлаачдын үзсэнчлэн хүн үүсэн буй болсон цагаасаа соёлыг бий болгож, түүнийгээ хөгжүүлж баяжуулж ирсэн. Соёлыг хүний оюун ухаан, хөдөлмөр шингэсэн материаллаг болон оюун санааны үнэт зүйлсийг бий болгодог, хүний амьдралын мөн чанарыг оршихуйн утга санаатай уялдуулсан бүтээлч үйлийн илрэх хэлбэр гэж үзэж болно¹.

Улс нийгмийн хөгжилд Соёл гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар 1960-аад оны үед нэлээд ерөнхий байдлаар тодорхойлж байсан бол, 1970-аад оноос нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд авч үзэх болсон. Харин 2010 онд НҮБ-ын Ерөнхий чуулганаар хэлэлцэж XXI зууны тогтвортой хөгжлийн зорилтод Соёл үүрэг оролцоо ихээхэн чухал болохыг онцолсон².

¹ Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ, төлөвлөлтийн арга зүй

² Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх, онол практикийн асуудал

БҮЛЭГ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Засгийн газраас Эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон, бодлогоор онцгойлон дэмжихээ зарласан салбар нь аялал жуулчлал болон бүтээлч эдийн засгийн салбар юм.

Бүтээлч эдийн засгийн салбар нь манай орны хувьд шинэ тутам хөгжиж буй салбар ч эдийн засгийг төрөлжүүлэхэд онцгой ач холбогдолтой, уул уурхайгаас дутахгүй орлого олох боломжтой салбар юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 74 дүгээр чуулганаар 2021 оныг **"Тогтвортой хөгжлийн төлөөх бүтээлч эдийн засгийн олон улсын жил"** хэмээн зарласан.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ түүх, соёл, зан заншил, өв уламжлал, ахуй амьдрал зэргийг харуулсан Соёл аливаа бүтээлийг гадаад зах зээлд гарахад нь хууль эрх зүйн таатай орчин, татварын бодлого гээд бүх талаар дэмжихээ илэрхийлсэн. Мөн Монгол Улс үндэсний өв баялаг соёлоо эдийн засгийн эргэлтэд оруулж, Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжсөн салбарыг бий болгож, бүтээлч, чадварлаг боловсон хүчний оюуны бүтээлээр дэлхийд өрсөлдөх нь хөгжлийн гарц болохыг онцолсон.

А. Олон улсын чиг хандлага

Дэлхий дахиныг хамарсан даяаршлын өнөөгийн нөхцөлд улс орнуудын өмнө, ялангуяа хөгжлөөр хоцрогдонгүй жижиг улсуудын хувьд нэг талаас, дэхийн хөгжилтэй хөл нийлүүлэн ижилсэх, нөгөө талаас үндэсний өвөрмөц онцлог, өв уламжлалаа хадгалан үлдэж, ондоошин ялгарах зорилт тулгарч байна. Энэ утгаараа ЮНЕСКО-оос “Соёлыг хүн төрөлхтний язгуур үнэт зүйл, улс үндэстний оршин тогтнохын нэг гол үндэс, тусгаар тогтнолын баталгаа болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, нийгэм, эдийн засгийн өсөлт, хөгжлийн нэг гол хэмжүүр нь Соёл хөгжил” гэдгийг тунхаглаж, Соёл хөгжлийг тэргүүн зэрэгт тавих уриалгыг гаргасан.

Улмаар 2005 онд “Соёл илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” конвенцыг баталсан нь нийгэм, эдийн засгийн хүрээнд Соёл гүйцэтгэх үүрэг, ойлголт өөрчлөгдөж, соёл болон хөгжлийн хоорондын хамаарлыг чухалчлах болсныг харуулах болсон. Уг конвенцын үзэл баримтлал, суурь зарчимтай уялдуулан дараах зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

1. Соёл засаглалын тогтвортой системийг дэмжих;
2. Соёл бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалыг бий болгох хийгээд уран бүтээлч болон Соёл мэргэжилтнүүдийн хөдөлгөөнийг нэмэгдүүлэх;
3. Соёлыг тогтвортой хөгжлийн хамрах хүрээнд нэгтгэх
4. Хүний эрх болоод суурь эрх чөлөөг хөхиүлэн дэмжих зэрэг болно. ЮНЕСКО-ийн 2005 оныг конвенцын тайлан (2018)-д дурдсаныг нэгтгэн дүгнэвэл:

Соёл олон төрөл нь Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, түгээлтийн нэмүү өртгийн сүлжээг дэмжих зорилгоор сүүлийн 10 гаруй жилд, Соёл бодлого, түүний шалгуур болон механизмуудыг шинэчлэх үйл явц эрчимтэй өрнөж байна. Технологи нь авьяастанд шинэ боломжийг бий болгохын хажуугаар хүн амын оролцооны шинэ хэлбэрүүд нь нэмүү өртгийн сүлжээн дэх Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний хоорондын заагийг дахин тодорхойлж, шинэ бодлого болон шалгуурыг загварчлан боловсруулах шаардлага байгааг харуулж байна.

Мөн 2012 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Соёл ба хөгжил” чуулганаас гаргасан “Улаанбаатарын тунхаглал”-д бүтээлч үйлдвэрлэл, Соёл аялал жуулчлал нь улс орны тогтвортой хөгжлийг хангахад голлох үүрэг гүйцэтгэнэ” хэмээн заасан нь манай

улсын хувьд ч Соёл тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг дэлхий дахины хөгжлийн хандлагатай уялдуулан авч үзэж байгааг харуулсан.

“Тогтвортой хөгжлийн 2030” хөтөлбөр нь эдийн засаг, нийгэм болон хүрээлэн буй орчин гэсэн 3 хүрээг хамарсан 17 зорилт бүхий үйл ажиллагааг хамруулсан хөгжлийн суурь үзэл баримтлал гэж үзэж болно. Тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, хүрээлэнбуй орчин гэсэн хүрээнүүд нь тус тусдаа салангид бус өөр хоорондоо харилцан уялдаа бүхий эрх, тэгш байдал болон тогтвортой байдлыг хангах бүхий л зарчмуудыг бүрэнхамруулдаг. Энэхүү өргөн цар хүрээтэй зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүх хүрээг тэгш хамарсан цогц бодлого хэрэгжүүлэхэд соёл чухал үүрэг гүйцэтгэх юм. Мөн “Соёл бодлогыг дахин тодорхойлох нь” 2018-д дурдсанаар “Тогтвортой хөгжлийн-2030” хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилтуудыг хангахад үр нөлөөтэй арга хэрэгсэл байх болно. Энэ утгаараа конвенцын үзэл санаа, суурь зарчимтай уялдуулан тодорхойлсон зорилтууд болог тогтвортой хөгжлийн зорилтуудын уялдаа дараах байдлаар тодорхойлогдож байна.

Зорилт 1. “Соёл засаглалын тогтвортой тогтолцоог дэмжих”-ын хувьд “Тогтвортой хөгжлийн зорилтууд болох 8,16, 17-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах Соёл засаглалын тогтвортой тогтолцоог дэмжих явдал юм. Конвенцыг хэрэгжүүлснээр хамтын засаглал, олон талт шийдвэр гаргах үйл явцад эерэг нөлөө үзүүлж эхэлсэн төдийгүй энэ нь хөгжиж буй зарим оронд, бүтээлч эдийн засаг, Соёл боловсролын салбарт мэдрэгдэж эхэлсэн.Соёл бодлогын тодорхой инновацыг бүс нутгийн болон орон нутгийн удирдлагууд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байна . Ялангуяа хөгжиж буй орнуудад бодлогын хэрэгжилт, бүтээлч нэмүү өртгийн сүлжээний санхүүжилт болон үзэгчдийн орон нутагт үйлдвэрлэсэн контентыг үзэх боломж нь хоорондоо харилцан хамааралтай гэжээ.

Зорилт 2. Соёл бүтээгдэхүүн , үйлчилгээний тэнцвэрт урсгалыг хангах , Соёл мэргэжилтэн , уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх"-ын хувьд" Тогтвортой хөгжлийн зорилтууд болох 8, 10" -ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Соёл бүтээгдэхүүн , урсгал болон Соёл мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг дэлхийн дахинд хангах юм. Соёл мэргэжилтэн, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн нь үнэт зүйлс, үзэл бодлын олон янзын ертөнц, дэлхийн үзэл санааг дэмжих, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Зорилт 3. "Соёл хүрээг тогтвортой хөгжлийн цар хүрээтэй уялдуулах " -ын хувьд" Тогтвортой хөгжлийн зорилтууд болох 4, 8, 17 " -ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах Соёл хүрээг тогтвортой хөгжлийн цар хүрээтэй уялдуулах урт хугацааны ажлыг урагшлуулах , түүнчлэн тогтвортой хөгжилд Соёл гүйцэтгэх үүргийг таниулахад нөлөөлсөн . Олон улсын тогтвортой хөгжлийн хэд хэдэн хөтөлбөрт Соёл асуудлыг гол хэсэг гэж авч үзжээ

Зорилт 4. "Хүний үндсэн эрх , эрх чөлөөг хөхиүлэн дэмжих "-ийн хувьд " Тогтвортой хөгжлийн зорилтууд болох 5 , 16 " -ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах харилцаа холбоо , мэдээлэл болон сүүлийн жилүүдэд хамгийн чухалд тооцогдох хүний үндсэн эрх , эрх чөлөөг хөхиүлэн дэмжих тухай конвенцын гол зарчимд үндэслэсэн . Жендерийн тэгш байдал нь гол хэмжүүр бөгөөд конвенцын хувьд жендерийн тэгш байдлыг хангах бодлого , арга хэрэгслийг шаардах , эмэгтэйчүүдийг Соёл бүтээгдэхүүн , үйлчилгээг үйлдвэрлэгч , уран бүтээлч хэмээн дэмжихийг чухалчилжээ.

Хорьдугаар зуунд улс орнуудын хөгжлийн чиг хандлага техник технологийн дэвшилд тулгуурласан , эдийн засгийн үр ашгийг чухалчилж байсан бол, XXI зуунд нийгэм, эдийн засгийн бүхий л асуудлуудад мэдлэг, оюуны үнэ цэнэ улам бүр нэмэгдэн, хөгжлийн тулгуур хүний хүчин зүйлд шилжих үйл явц эрчимтэй өрнөж байна. Улс орны өрсөлдөх чадвар хүний тоо , газар нутгийн хэмжээ, байгалийн баялгаар бус, харин мэдлэг оюунд түшиглэн нөөцөө хэрхэн үр өгөөжтэй ашиглаж байгаагаас ихээхэн хамаарч , үүнд

инновац шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болов. Шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай, хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацын үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, түүнийг баримжаалах явдал нийгэм, эдийн засгийн хөгжлийн цоо шинэ хандлагыг тодорхойлох болжээ. Иймд нийгмийн дэвшил, эдийн засгийн хөгжилд мэдлэг хийгээд, Соёл гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөн чухалчлан авч үзэх болсон. Иймээс соёлыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн үйл явцаас салгаж, тусад нь авч үзэх боломжгүй юм. Дэлхийн улс орнуудад бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг хэмээн чухалчлахад дараах шинэ боломж, нөхцөлүүд нөлөөлсөн. Үүнд:

- Дэлхийн нийтийн даяаршил нь Соёл бараа, үйлчилгээг олон улсын хэв шинжтэй болгож, олон улсын хэмжээнд солилцох нөхцөл бүрдсэн. Улмаар Соёл олон төрөл, Соёл харилцан нөлөөлөл нь шинэ бүтээгдэхүүн, шинэ дадал зэрэг олон төстэй зүйлүүдийг бий болгосон.
- Дэлхий нийтээр үйлдвэрлэлийн аналог технологиос дижитал технологид шилжсэн нь Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний хэв загвар, үйлдвэрлэл, түгээлтэд шинэ боломжууд бий болж, улмаар эдийн засгийн ач холбогдол нь өсөн нэмэгдэх бололцоо бүрдсэн.
- Дэлхийн ихэнх бүс нутагт чинээлэг хангалуун байдал, чөлөөт орлого нэмэгдсэнээр Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээнд зориулах хүн амын зарлага нэмэгдэж, Соёл хэрэглээ, бүтээгдэхүүний хамрах хүрээ өссөн.

Энэ хөгжлийн шинэ нөхцөл байдал хөгжингүй буюу хөгжиж буй улс орнуудад Соёл салбар нь бусад салбаруудтай (уул уурхай, автомашины үйлдвэрлэл гэх мэт) харьцуулахад эдийн засгийн ач холбогдол нь нэмэгдэж, экспортын хувь оролцоо мэдэгдэхүйц өсөж эхэлсэн. Өнөөгийн байдлаар олон улсад 3Т хандлагыг үндэс болгон "Дэлхийн бүтээлч байдлын индекс" (Global Creativity Index)-ийг тооцоолдог. Тухайлбал, улс орнуудын "Бүтээлч байдал"-ын 2015 оны жагсаалтад 139 орноос Австрали (0.970) тэргүүлж, Америк (0.950), Шинэ Зеланд (0.949) удаалсан бол, ОХУ (0.579) 38-д, Хятад (0.456) 62-д орж, манай улс 0.370 оноогоор 81-р байрт оржээ. Үүнийг 2011 оны үзүүлэлттэй харьцуулж үзвэл, тухайн үед манай улс 0.270 оноогоор 69-р байранд орж байсантай харьцуулахад 12 байраар ухарсан нь улс орнуудын бүтээлч байдал дээшилж, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг төрийн бодлогын хүрээнд ихээхэн анхаарал хандуулж байгааг харуулж байх талтай. Харин манай улсын хувьд Технологи: 2012 онд тооцогдоогүй байсан бол 2015 онд 75-д, Авьяас чадвар: 2012 онд 51-д байсан бол 2015 онд 47-д орж дээшилсэн ба хүлээцтэй байдал: 2012 онд 73-д байсан бол 2015 онд 98-д орж доошилсон үзүүлэлттэй байна (Ж.Эрхэмтөгс, 2019)

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Хүснэгт 2. Олон улсын бүтээлч байдлын үзүүлэлтүүдийн харьцуулалт

№	Улс орон	Технологи			Авьяас чадвар			Хүлээцтэй байдал			2011		2015	
		2011	2015	2020	2011	2015	2020	2011	2015	2020	GCI	Байр	GCI	Байр
1	Швед	5	11	11	2	8	8	7	10	10	0.923	1	0.915	7
2	АНУ	3	4	4	8	3	20	8	11	5	0.902	2	0.950	2
3	Финлянд	1	5	5	1	3	3	19	20	20	0.894	3	0.917	5
4	Дани	7	10	10	4	6	6	14	13	13	0.878	4	0.917	5
5	Австрали	15	7	7	7	1	1	5	4	4	0.870	5	0.970	1
6	Шинэ зеланд	19	7	7	5	8	8	4	3	3	0.866	6	0.949	3
7	Канад	11	13	13	17	14	14	1	1	1	0.862	7	0.920	4
8	Норвег	12	18	18	6	12	12	11	9	9	0.862	8	0.883	11
9	Сингапур	10	7	7	3	5	5	17	23	23	0.858	9	0.896	9
10	Нидерланд	17	20	20	11	11	11	3	6	6	0.885	10	0.889	10
11	Солонгос	8	1	1	24	50	50	62	70	70	0.598	27	0.660	31
12	Япон	2	2	2	45	58	58	61	39	39	0.541	30	0.708	24
13	ОХУ	21	22	22	13	15	15	74	123	123	0.541	30	0.579	38
14	Казакстан	60	72	72	40	54	54	57	98	98	0.341	54	0.357	84
15	Хятад	30	14	14	76	87	87	-	96	96	0.327	58	0.456	62
16	Монгол	-	75	72	51	47	54	73	98	98	0.270	69	0.370	81

Эх сурвалж: Дэлхийн бүтээлч байдлын индекс

Иймд улс орнууд бүтээлч эдийн засгийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, улмаар эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс нь ЗТ хандлагаар тодорхойлогдож байна. Энэхүү үнэлгээ нь "ЗТ" буюу "Технологи" (Technology), "Авьяас чадвар" (Talent), "Хүлээцтэй хандлага"(Tolerance) гэсэн загварын үзэл баримтлалд тулгуурласан. Уг загварын гол агуулга, үзэл санаа нь улс орон, түүний бүс нутаг, хотуудын хөгжил нь бүтээлч үйлдвэрлэлээс ихээхэн хамаардаг ба уг салбарыг хөгжүүлэх зайлшгүй болоод хүрэлцээтэй нөхцөл нь шинэ техник технологи бий болгох технологийн хөгжил, дэвшил (Technology), тэдгээрийг бүтээх мэдлэг, чадвар бүхий хүний нөөц (Talent) - тэй байх, хүн авьяас чадвараа дайчлан, хүссэн зорьсон зүйлээ хэрэгжүүлэх, бүтээлчээр ажиллаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх гол үндэс болох нийгмийн аливаа асуудал, тэр дундаа нийгмийн цөөнхөд хүлээцтэй хандах гэсэн 3 хүчин зүйлс нэгдмэл байх явдал гэж үздэгт оршино.

Оюуны өмчийн эрх бүхий бараа, үйлчилгээг тодорхойлох нь эдийн засгийн үйл ажиллагааг бүхэлд нь хамардаг үндэсний эдийн засагт Соёл оруулж буй чухал хувь нэмэр болно. Үндэсний тооцооны системд орлого, хөдөлмөр эрхлэлт зэрэг хэлбэрээр үндэсний эдийн засагт бүтээлч үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмрийг тодорхойлох хэрэгсэл болдог. Бүтээлч эдийн засгийн чиглэлээр олон улсын байгууллагуудаас цөөнгүй судалгаа хийгджээ. Тухайлбал:

- ЮНЕСКО (2003)-оос гаргасан судалгаанаас үзэхэд бүтээлч үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 1994, 2002 онуудад 39.2-аас 59.2 тэрбум ам.долларт хүрч 51 хувиар өсжээ.
- Европын Зөвлөл (2006)-өөс Соёл эдийн засгийн чиглэлээр явуулсан судалгаанаас үзэхэд 2003 онд Соёл салбар Европын холбооны ДНБ-ний 2.6 хувийг үйлдвэрлэсэн бол, үл хөдлөх хөрөнгийн худалдаа 2.1 хувь, хоол хүнс, ундаа, тамхины үйлдвэрлэл 1.9 хувь, даавууны үйлдвэрлэл 0.5 хувийг тус тус эзэлжээ. Мөн уг салбарт 2004 он гэхэд 5.8 сая хүн ажиллаж байсан нь нийт ажиллах хүчний 3.1 хувийг бүрдүүлж байжээ. Харин 2013 оны байдлаар ДНБ-ний 6.2 хувийг үйлдвэрлэж, ажиллах хүчний 5.2 хувийг бүрдүүлж байна.
- ЮНКТАД (2013) -ын тайланд тусгагдсанаар 2011 оны байдлаар дэлхийн Соёл бүтээгдэхүүн, үйлчилгээний жилийн эргэлт 624 тэрбум ам.долларт хүрсэн нь 2002 онтой харьцуулахад 10 гаруй дахин өссөн буюу жилийн дундаж өсөлт нь 8.8 хувьтай тэнцүү, мөн хөгжиж буй улс орнуудын бүтээлч барааны экспортын жилийн дундаж өсөлт 12.1 хувь байгаа нь сүүлийн жилүүдэд хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засгийн салбар гэдгийг харуулж байгаа юм.
- ЮНЕСКО (2018)-оос Соёл илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцын хэрэгжилтийг хянах зорилгоор гаргасан "Соёл бодлогыг дахин тодорхойлох нь тайланд тодорхойлсноор дэлхий дахинд бүтээлч үйлдвэрлэлийн хэмжээ 2,250 тэрбум ам.долларт хүрч, уг салбар 30 сая хүн ажиллаж байна. Соёл бүтээгдэхүүний дэлхийн экспортын хэмжээ 2014 оны байдлаар 253.2 тэрбум ам.доллар, харин хөгжмийн үйлдвэрлэл дэх цахим борлуулалт 2016 оны байдлаар 7.85 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Түүнчлэн зарим томоохон улс орнуудын хувьд ч уг салбар ихээхэн эрчимтэй хөгжиж, тухайлбал, 2010 оны байдлаар бүтээлч үйлдвэрлэлийн салбар Энэтхэг улс гэхэд ДНБ - ний 1.5 хувь, Бразил улсад 2.5 хувь, ОХУ - д 6.0 хувь, Өмнөд Африкт 4.1 хувь тус тус хүрчээ. Хятад улсын хувьд 2012 оны байдлаар уг салбарын үйлдвэрлэлт ДНБ-ний 3.8 хувь буюу 1.8 тэрбум юаньд хүрсэн нь 2003 онтой харьцуулахад 60 дахин өсжээ (Ж.Эрхэмтөгс, 2019).

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Хүснэгт 3. Улс орнуудын зах зээлийг хөгжүүлэх бодлогын чиглэлүүд

№	Улс орнууд	Бодлогын чиглэл	Дэмжих чиглэл
1	Финлянд	Соёл экспортыг дэмжих хөтөлбөр	Бүтээлч үйлдвэрлэл
2	Нидерланд	Соёл экспортыг дэмжих хөтөлбөр	Бүтээлч үйлдвэрлэл
3	Шинэ Зеланд	Хэрэглэгч ба зах зээл хөгжүүлэх стратеги	Бүтээлч үйлдвэрлэл
4	Сингапур	Бүтээлч бизнес сан	Бүтээлч үйлдвэрлэл
5	Англи	Бүтээлч үйлдвэрлэлийн олон улсын худалдааны стратеги	Бүтээлч үйлдвэрлэл
6	Испани	Соёл бүтээгдэхүүнийг дэмжих хөтөлбөр	Бүтээлч үйлдвэрлэл

Мөн дэлхийн улс орнуудын бүтээлч байдлыг илэрхийлдэг “Глобал бүтээлч байдлын индекс”-ийн тайланд 2020 онд Монгол улс нийт 139 улсаас 81-рт, Глобал инновацын индексээр 58-рт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь дэлхийн дундаж үзүүлэлттэй харьцуулбал бүтээлч байдал дунджаас доогуур, харин инновацын индексээр дээгүүр жагсаж байна (Ж.Эрхэмтөгс, 2019).

Хүснэгт 4. Глобал инновацын индекс

Улс	Дэлхийн улс орнуудын инновацын дэд индексийн түвшин		Дэлхийн улс орнуудын 2020 оны инновацын түвшин
	Орцын дэд индекс	Гарцын дэд индекс	
АНУ	4	5	3
Япон	12	18	16
Солонгос	10	10	10
Их Британи	6	3	4
ОХУ	42	58	47
Монгол	65	54	58
Казакстан	60	94	77
Киргизстан	88	107	94

Соёл бүтээлч үйлдвэрлэл гэдэг нь бүтээлч хандлагад тулгуурлан, оюуны өмчийн эрхийн баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, түгээх, байдлаар ашиг, орлого ажлын байр бий болгох инновацад суурилсан үйл ажиллагаа, түүний үр дүн юм. Бүтээлч үйлдвэрлэлийг дэлхийн улс орнуудад мэдлэгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг хэмээн үзэж үндэсний инновацын тогтолцооны хүрээнд дэмжин хөгжүүлж байна. Энэ салбар нь дэлхийн эдийн засгийн 6.1%-ийг бүрдүүлж жилд дунджаар 2250 тэрбум ам.долларын орлого олж, 30 сая ажлын байрыг бий болгож байна. Түүнчлэн соёл нь эдийн засгийн нөөц болохын сацуу нийгмийн инновацыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна (Ж.Эрхэмтөгс, 2019).

Б. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахад шаардлагатай суурь хүчин зүйлүүдийн нөөц, чадавх

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын ААНБ болон ажиллагсдын тоог харгалзан авч үзсэн нь хөдөлмөрт суурилсан буюу гол хөдөлгөгч хүчин зүйл бол хүмүүн капитал гэдгийг харуулахыг зорьсон. Тус нөөцийг харуулахдаа нийт ажилчид болон ААНБ, төгсөгчдийн тоог авч үзлээ. Өөрөөр хэлбэл урт хугацаанд үйлдвэрлэлийн процесст ашиглагдах хүний хөдөлмөрийн үр дүнд бий болох Соёл бүтээлч үйлдвэрлэлийн хамгийн гол хүчин зүйл бол хүмүүн капитал юм. Мөн олон улсын судалгаануудад чадварлаг хүний нөөцийн ур чадвар нь СБҮ-ийн салбарыг хөгжүүлэх суурь үндэс байдаг хэмээн үзэж байна. Тухайлбал, Их британи улсын парламентын гишүүдээс авсан судалгаанд “Боловсрол болон ур чадвар нь бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг урт хугацаанд амжилттай хөгжүүлэх гол хөдөлгөгч хүч” хэмээн нийт судалгаанд оролцогчдын 37 хувь нь үзсэн байдаг (Panel, 2015).

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын бүртгэлтэй аж ахуй нэгж, байгууллагын тоо:


Хүснэгт 5. СБҮ-ийн салбарын бүртгэлтэй ААНБ-ын тоо, 2020 оны байдлаар

Салбар	СС	ТТДМ	ХС	Нийт
А. Соёл болон байгалийн өв	3824			3824
Өв соёл	3824			3824
Б. Урлагийн тоглолт, баяр наадам	594	101		694
Дуу, хөгжим	396	60		455
Тайзны урлаг	198	41		239
В. Дүрслэх урлаг, гар урлал	1132	107		1239
Дүрслэх урлаг	1132	107		1239
Г. Утга зохиол, ном хэвлэл	1818	1101		2919
Утга зохиол, ном хэвлэл	1460	802		2261
Хэвлэл мэдээлэл	358	299		657
Д. Аудио, дүрс бичлэг, интерактив мэдээллийн хэрэгсэл	1933	5858		7791
Кино, дуу дүрсний урлаг	688	449		1137
Хэвлэл мэдээлэл	1168	802		1970
Дижитал инновац, контент	77	4608		4685
Е. Загвар болон бүтээлч үйлчилгээ	2397	2273		4670
Хувцас загвар		1841		1841
Архитектур	1724			1724
Дизайн	241			241
Маркетинг зар сурталчилгаа	432	432		864
Холбогдох салбар			17221	17221
Аялал жуулчлал			9715	9715
Спорт, чөлөөт цаг			7506	7506
Нийт	11697	9440	17221	38358

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Зураг 1. СБҮ-ийн салбарын бүртгэлтэй ААНБ - ын тоо, салбараар



Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

СБҮ-ийн салбарын эдийн засгийн 38358 ААНБ бүртгэлтэй байгаагаас 16055 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 9958 нь СБҮ-ийн салбарын ААНБ байгаа бөгөөд 5665 нь Соёл болон бүтээлч үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байна.

Хүснэгт 6. СБҮ-ийн салбарын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ - ын тоо, 2020 оны байдлаар.


Салбар	СС	ТТДМ	XC	Нийт
А. Соёл болон байгалийн өв	2237			2237
Өв соёл				2237
Б. Урлагийн тоглолт, баяр наадам	303	34		337
Дуу, хөгжим	175	16		190
Тайзны урлаг	129	18		147
В. Дүрслэх урлаг, гар урлал	495	51		546
Дүрслэх урлаг	495	51		546
Г. Утга зохиол, ном хэвлэл	782	568		1351
Утга зохиол, ном хэвлэл	654	463		1117
Хэвлэл мэдээлэл	128	105		234
Д. Аудио, дүрс бичлэг, интерактив мэдээллийн хэрэгсэл	716	2536		3252
Кино, дуу дүрсний урлаг	294	275		569
Хэвлэл мэдээлэл	395	460		855
Дижитал инновац, контент	28	1801		1829
Е. Загвар болон бүтээлч үйлчилгээ	1132	1105		2236
Хувцас загвар		902		902
Архитектур	834			834
Дизайн	95			95
Маркетинг зар сурталчилгаа	203	203		405
Холбогдох салбар			6097	6097
Аялал жуулчлал			2843	2843
Спорт, чөлөөт цаг			3254	3254
Нийт	5665	4293	6097	16055

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоог авч үзвэл нийт 16055 байгаа үүнээс СС 5665, ТТДМ 4293, ХС 6097 байна.

Зураг 2. СБҮ -ийн салбарын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ - ын тоо, 2020 оны байдлаар



Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын ажилчдын тоо:

Нийт Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг хүйсээр нь авч үзвэл 48% нь эмэгтэй, 52% нь эрэгтэй буюу нийт ажиллах хүчин 74871 байна.

Хүснэгт 7. СБҮ-ийн салбарын ажиллагчдын тоо, СБҮ–д хамаарах чиглэлээр


СБҮ-д хамаарах чиглэл	Нийт дүн	Хувь
Соёл салбар	33931	45%
ТТДМ	26732	36%
Нийтлэг хамааралтай салбар	12872	17%
Холбогдох салбар	1337	2%
Нийт ажиллах хүчин	74871	100%

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн хамаарах чиглэлээр авч үзвэл Соёл салбар 45% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байгаа буюу 33931 ажилтан байна.


Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Зураг 3. СБҮ-ийн салбарын ажиллагчдын тоо, СБҮ - д хамаарах чиглэлээр, дүнгээр



Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Зураг 4. СБҮ-ийн салбарын ажиллах хүчний нас, хүйсээр



Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Нас болон хүйсээр авч үзвэл 30-34 насны эрэгтэй, эмэгтэй ажиллагсад хамгийн өндөр хувиар эзэлж байгаа ба 15-19, 50+ харьцангуй бага байгаа нь харагдаж байна. Хүйсийн харьцааны хувьд тус салбарын 40-өөс дээш насны эмэгтэй их байгаа бол 15-аас 40 нас хүртэлх эрэгтэй ажилчдын тоо харьцангуй их харагдаж байна.

Хүснэгт 8. СБҮ - ийн салбарын ажиллагчдын тоо, салбараар


Салбар	Нийт	Эмэгтэй нийт
А. Өв соёл	4843	3360
Өв соёл	4843	3360
Б. Урлагийн тоглолт, баяр наадам	1820	1208
Дуу хөгжим	1182	883
Тайзны урлаг	639	325
Биет бус Соёл өв	12872	4400
Өв соёл	12872	4400
В. Дүрслэх урлаг, гар урлал	32821	19348
Дүрслэх урлаг, гар урлал	12538	2801

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Хувцас загвар	20282	16547
Г. Ном хэвлэл	6810	3510
Утга зохиол, ном хэвлэл	6810	3510
Д. Аудио, дүрс бичлэг, интерактив хэрэгсэлүүд	6007	2035
Кино урлаг	847	126
Хэвлэл мэдээлэл	1872	852
Дижитал инновац, контент	3288	1057
Е. Дизайн, бүтээлч үйлчилгээ	8362	4014
Хувцас загвар	201	201
Архитектур	3886	1347
Дизайн	1413	911
Маркетинг, зар сурталчилгаа	2861	1555
Холбогдох салбар	1337	1048
Аялал жуулчлал	1237	1048
Спорт чөлөөт цаг	100	-
Нийт	74871	38925

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Зураг 5. СБҮ - ийн салбарын ажиллагчдын тоо, нийт дүнгээр



Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Салбар	Соёлын салбар	Үүнээс: эмэгтэй	ТТДМ	Үүнээс: эмэгтэй	Нийтлэг хамааралтай салбар	Үүнээс: эмэгтэй	Холбогдох салбар	Үүнээс: эмэгтэй	Нийт	Үүнээс: эмэгтэй
Өв соёл	4843	3360			12872	4400			17714	7761
Утга зохиол, ном хэвлэл	5442	3510	1368	-					6810	3510
Дүрслэх урлаг, гар урлал	11793	2652	745	149					12538	2801
Дуу хөгжим	1182	883							1182	883
Тайзны урлаг	639	325							639	325
Кино урлаг	847	126							847	126
Хэвлэл мэдээлэл	824	598	1048	254					1872	852
Хувцас загвар	201	201	20282	16547					20484	16748
Архитектур	3886	1347							3886	1347
Дизайн	1413	911							1413	911
Дижитал инновац, контент			3288	1057					3288	1057
Маркетинг, зар сурталчилгаа	2861	1555							2861	1555
А: Аялал жуулчлал							1237	1048	1237	1048
В: Спорт чөлөөт цаг							100	-	100	-
Нийт	33931	15469	26732	18007	12872	4400	1337	1048	74871	38925

Хүснэгт 9. СБҮ - ийн салбарын ажиллагчдын тоо, салбар, хүйсээр, 2020 оны байдлаар

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

СБҮ - ийн салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, нас хүйсээр:

2020 оны байдлаар СБҮ -ийн салбарын нийт 2721 хөгжлийн бэрхшээлтэй ажиллагч байна. Тэдгээрийн 40% нь эрэгтэй, 60% нь эмэгтэй ажиллагчид байна.

Хүснэгт 10. ХБ ажиллагчдын тоо, жилээр

Он	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй
2010	311	62	248
2011	356	126	230
2012	1048	619	429
2013	2404	780	1624
2014	1644	655	989
2015	1905	1214	691
2016	1860	691	1169
2017	2719	1027	1692
2018	2272	1230	1043
2019	1742	1234	508
2020	2721	1635	1086

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

СБҮ салбарт ажиллаж буй нийт хөгжлийн бэрхшээлтэй ажиллагчдын дийлэнх нь орлуулагч хэлмэрч, нэхмэл, гар урлал, программ зохиогч зэрэг ажил хамгийн их эрхэлж байна.

Хүснэгт 11. ХБ ажиллагчдын тоо, ажил мэргэжлээр, 2020 оны байдлаар

Мэргэжил	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй
Орчуулагч, хэлмэрч, бусад хэл шинжээч	881	390	491
Нэхмэл, даавуу, арьс, бусад материалаар гар урлалын зүйлс хийгч	808	808	-
Хэрэглээний программ зохиогч	437	437	-
Дүрслэх урлаач	256	-	256
Энэ ангилалд ороогүй гар урлалын зүйл хийгч	130	-	130
Өөрөө удирдах нутгийн байгууллагын Засаг дарга, Захирагч, бусад удирдах албан тушаалтан	97	-	97
Зар сурталчилгаа, олон нийттэй харилцах менежер	58	-	58
Мэдээлэл холбооны технологи үйлчилгээний менежер	39	-	39
Аль нэг ангилалд ороогүй мэргэшсэн	15	-	15

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Боловсролын салбарын үзүүлэлтүүд:

СБҮ-ийн салбарын чиглэлээр төгссөн оюутны тоо-3880

2019-2020 оны хичээлийн жилд нийт 28045 хүн их дээд сургууль төгсжээ. Үүний 3880 нь СБҮ - ийн салбарт хамаарах төгсөгчид байна.

Төгсөгчдийн хүйсийн харьцаа:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Төгсөгчдийн хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй 46% , эрэгтэй 54%-ийг эзэлж байна. Нийт 3880 төгсөгч энэ онд төгсөнө.

Төгсөгчдийн тоо боловсролын зэргээр:

Төгсөгчдийн бакалаврын зэрэг 87.45%, магистрын зэрэг 11.6%, дипломын боловсрол 0.3%, докторын зэрэг 0.7%-ийг эзэлж байна.

Хүснэгт 12. СБҮ - ийн салбарын төгсөгчдийн тоо, салбараар, 2019-2020 оны байдлаар

Салбар	Нийт төгсөгчид	Эмэгтэй
А. Өв соёл	268	201
Өв соёл	268	201
Б. Урлагийн тоглолт, баяр наадам	459	234
Дуу хөгжим	185	78
Тайзны урлаг	274	156
В. Дүрслэх урлаг, гар урлал	78	33
Дүрслэх урлаг	78	33
Г. Ном, хэвлэл	442	327
Утга зохиол	442	327
Д. Аудио, дүрс бичлэг, интерактив хэрэгслүүд	47	10
Кино урлаг	32	8
Хэвлэл мэдээлэл	15	2
Дизайн, бүтээлч үйлчилгээ	1109	493
Дизайн	150	64
Дижитал инноваци	336	85
Маркетинг, зар сурталчилгаа	202	91
Хувцас загвар	148	132
Архитектур дизайн	273	121
Холбогдох салбар	1477	801
А. Аялал жуулчлал	152	83
В. Спорт, чөлөөт цаг	562	128
С. Соёл боловсрол	763	590
Нийт	3880	2099

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Хүснэгт 13. Их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн хөтөлбөрийн тоо

Салбар	Мэргэжлийн хөтөлбөрийн тоо
Улсын дүн	2451
СБҮ - ийн нийт ЭЗ	449
СБҮ - ийн 12 салбар	339
1. Өв соёл	39
2. Утга зохиол, ном хэвлэл	19
3. Дүрслэх урлаг	17
4. Дуу, хөгжим	36
5. Тайзны урлаг	31
6. Кино, дуу дүрсний урлаг	21

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

7. Хэвлэл мэдээлэл	24
8. Хувцас загвар	19
9. Архитектур	21
10. Дизайн	22
11. Дижитал инновац, контент	53
12. Маркетинг, зар сурталчилгаа	37
Холбогдох салбар	110
А. Аялал жуулчлал	29
В. Спорт чөлөөт цаг	14
С. Соёл боловсрол	67

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

Хүснэгт 14. СБҮ - ийн салбарын төгсөгчдийн тоо, хөтөлбөрийн чиглэлээр, 2019-2020

Салбар хөтөлбөрийн чиглэлээр	Нийт төгсөгчид	Үүнээс: эмэгтэй
1. Өв соёл	268	201
Бусад хүмүүнлэгийн ухааны салбар	158	137
Монгол судлал	5	3
Олон улс, орон судлал	126	118
Түүх	27	16
Нийгмийн шинжлэх ухаан	23	7
Антропологи	12	4
Археологи	11	3
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	60	48
Архив судлал	43	38
Соёл судлал	16	10
Цэргийн түүх судлал	1	0
Шашин ба технологи	27	9
Философи	25	8
Шашин судлал	2	1
2. Утга зохиол	442	327
Бусад хүмүүнлэгийн ухааны салбар	387	299
Гадаад хэлний орчуулга	343	265
Утга зохиол судлал	44	34
Нийгмийн шинжлэх ухаан	55	28
Номын сан судлал, мэдээлэл	55	28
3. Дүрслэх урлаг	78	33
Уран зураг	78	33
Дарханы урлаг	1	0
Зураасан зураг	5	2
Керамик вааран урлал	2	1
Монгол зураг	6	6
Тайз, дэлгэцийн зураг	1	1
Түүх Соёл дурсгалт зүйлийн сэргээн засварлалт	1	1
Уран баримал	19	4
Уран зураг	43	18
Чимэглэх урлаг	0	0

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

4. Дуу, хөгжим	194	80
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	194	80
Дуу чимээний технологи	5	0
Дуулах урлаг	74	37
Дуурийн дуу	18	8
Найрал хөгжим удирдах урлаг	0	0
Төгөлдөр хуур	5	4
Удирдаач	4	0
Уртын дуу	5	2
Утсан хөгжим	1	0
Үлээвэр хөгжим	3	1
Үндэсний хөгжим	6	1
Хөгжимдөх урлаг	62	25
Хөгжмийн зохиомж	1	0
Хөгжмийн урлаг	10	2
5. Тайзны урлаг	265	154
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	265	154
Бүжгийн багш	5	3
Бүжгийн урлаг	9	6
Гоо заслын урлаг, технологи	36	35
Жүжиглэх урлаг	109	53
Найруулах урлаг	52	22
Тайзнаас ярих урлаг	1	1
Урлаг судлал	31	22
Урлагийн боловсрол	7	7
Үндэсний язгуур урлаг	15	5
6. Кино урлаг	32	8
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	32	8
Зураг авалт	19	3
Кино, драмын жүжгийн урлаг	11	5
Медиа үйлдвэрлэл	2	0
7. Хэвлэл мэдээлэл	15	2
Нийгмийн шинжлэх ухаан	7	1
Кино телевизийн зураглаач	2	0
Телевизийн сэтгүүл зүй	2	0
Телевизийн сэтгүүлч	2	0
Телевизийн сэтгүүлч, найруулагч	1	1
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	8	1
Радио, дэлгэцийн технологи	8	1
8. Хувцас загвар	148	132
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	145	129
Хувцасны дизайн	145	129
Үйлдвэрлэл, үйл явц	3	3
Нэхмэл эдлэлийн дизайн	2	2
Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт	1	1
9. Архитектур дизайн	273	121
Инженер	166	67

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Архитектур	166	67
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	73	42
Интерьер дизайн	73	42
Хөдөө аж ахуй	34	12
Ландшафтын архитектур	34	12
10. Дизайн	150	64
Инженер	9	8
Материал судлал	9	8
Компьютерын шинжлэх ухаан:	116	45
График дизайн	116	45
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	24	11
Үйлдвэрлэлийн дизайн	24	11
Үйлдвэрлэл, үйл явц	1	0
Мебель модон эдлэлийн дизайн	1	0
11. Дижитал инноваци, контент	336	85
Компьютерын шинжлэх ухаан:	336	85
Мэдээллийн систем	73	25
Программ хангамж	258	60
Программист	5	0
12. Маркетинг, зар сурталчилгаа	202	91
Бөөний худалдаа, маркетинг, борлуулалт, олон нийттэй харилцах, үл хөдлөх хөрөнгө;	202	91
Маркетинг	202	91
А. Аялал жуулчлал	152	83
Бөөний худалдаа, маркетинг, борлуулалт, олон нийттэй харилцах, үл хөдлөх хөрөнгө;	37	26
Зочлох үйлчилгээ	37	26
Хувийн үйлчилгээ	115	57
Аялал жуулчлал	115	57
В. Спорт чөлөөт цаг	562	128
Боловсрол	562	128
Багш, биеийн тамирын боловсрол	406	106
Багш, спортын дасгалжуулагч	156	22
С. Соёл боловсрол	763	590
Боловсрол	640	488
Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	346	306
Багш, мэдээлэл зүйн	16	4
Багш, урлагийн боловсрол	182	109
Багш, урлагийн боловсрол /бүжгийн/	82	63
Дуу хөгжмийн боловсрол, урлагийн боловсрол	2	1
Дүрслэх урлаг, технологийн багш	12	5
Боловсролын шинжлэх ухаан	123	102
Виртуал сургалтын систем	5	2
Хэл шинжлэл	118	100
Нийт	3880	2099

Эх сурвалж: Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа

БҮЛЭГ 5. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Олон улсад хүлээн зөвшөөрөхүйц Соёл бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж чадсан Нидерланд, Солонгос, Япон, Тайван зэрэг орнуудыг сонгон авч тэдгээрийн хөгжлийн бодлого, хамрах хүрээ, ерөнхий төлөвлөгөөг судлан авч үзлээ.

1. Медиа Парк, Хилверсум, Нидерланд:



Амстердамаас 30 минутын зайтай Hilversum Media Park нь Европ дахь хамгийн чухал бүтээлч кластеруудын нэг бөгөөд Голландын хэвлэл мэдээллийн салбарын төв юм. 12 мянга гаруй ажлын байр, гарааны бизнес эрхлэгчид, мэргэжлийн хэвлэл мэдээллийн компаниудаас томоохон өргөн нэвтрүүлэгчид (үндэсний өргөн нэвтрүүлгийн NPO гэх мэт) хүртэлх 250 гаруй компанитай ба хамгийн сүүлийн үеийн технологийн дэд бүтэц, орчин

үеийн уян хатан байгууламж, олон төрлийн нийгмийн үйл ажиллагаа зэрэг хувийн болон мэргэжлийн олон үйлчилгээг үзүүлдэг. Мөн бүтээлч эсвэл хэвлэл мэдээллийн кампус хэлбэрээр ажилладаг боловч Рандстад хотын нутаг дэвсгэр дэх бүтээлч бизнесүүдтэй нийлүүлэлтийн сүлжээний хүчтэй харилцаатай бөгөөд бүтээлч бизнесийн сүлжээ, бүтээлч болон хэвлэл мэдээллийн шоуны арга хэмжээнүүд, гол их сургуулиудтай түншлэлээр харилцдаг байна.

Hilversum нь хүчирхэг төр, хувийн хэвшлийн түншлэл, арилжааны орон зай, хэрэглээний орон зай, суралцах инновацийн орон зайг бий болгож уян хатан тэнцвэртэйгээр ажилладаг. Энэ нь цаашлаад Хилверсум хотын захиргаа болон Медиа Паркийн аж ахуйн нэгжийн хамтран эхлүүлсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу цогц төлөвлөлтийн сэтгэлгээнд тусгагдсан ба оршин суугчдын амьдрах, ажиллах, бизнес эрхлэх боломжийг хангахад анхаарч, хамтын ажиллагаа, инновац, байгалийн үр дүнд цэцэглэн хөгжинө хэмээн зорилго тавьсан байна. Жишээ нь:

- Авсаархан хамтын орон зай, олон түрээслэгчийн байрнаас эхлээд нэг компанийн хувийн барилга хүртэл орчин үеийн, уян хатан оффисын өрөөнүүд;
- Мэргэжлийн техникийн үйлчилгээ бүхий олон үйлдэлт байр түрээслүүлнэ;
- Кампус доторх тусламж үйлчилгээний сүлжээ, үүнд нийтийн хоол, хувийн үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээ;
- Тайзны ард тайзны ард нэвтрэх, үзэгчдийг хөгжүүлэх төслүүд гэх мэт олон нийтийн идэвхтэй оролцооны хөтөлбөр;
- Соёл урлагийн их, дээд сургуулиудтай холбоотой ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд.

Зайлшгүй шаардлага: Голландын бүтээлч салбарын гол салбар болох Хэвлэл мэдээллийн салбар нь хөгжиж, сүүлийн 10 жилд 60,000 гаруй ажлын байр нэмэгдүүлжээ. Гэсэн хэдий ч, хэвлэл мэдээллийн салбар хүчтэй байр сууриа алдах боломжтой болж,

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

шилжилтийн шатандаа байна. Голландын хэвлэл мэдээллийн контент хөгжүүлэгчийн тэргүүлэгч дэлхийн байр суурь буурч байна. Энэ нь Голландын мэдээллийн хэрэгслийн орлого олох чадавхад (BV Nederland), түүний дотор орон нутгийн болон Соёл өвөрмөц байдалд хүчтэй сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Алсын харааг идэвхжүүлэх: Арга зүй – Зорилго тодорхойлох, сонирхол татах, зураглал бий болгоно. Энэхүү алсын хараа нь тухайн салбар юу болж байгааг үнэлэхийн тулд хийсэн нарийн судалгааны үр дүн юм: Энэ нь Нидерландын орлого олох чадавхыг нэмэгдүүлэхийн тулд байр сууриа хэрхэн хадгалах вэ гэдгийг тодорхойлох. Мөн энэ нь Голландын өвөрмөц байдал, соёлыг нэгэн зэрэг хүчирхэгжүүлж, Их Амстердам, Утрехт бүс нутгийг олон улсын сонирхол татахуйц байдлаар хэрхэн баталгаажуулах вэ гэдгийг тодорхойлох юм.

Хотын алсын харааны зорилго нь:

1. Салбарын өнгөрсөн үеийн түүхийг баялаг болгон хүлээн авах,
2. Бүтээлч сэтгэлгээг хөхиүлэн дэмжих, нийгмийн эв нэгдлийг бий болгох, өөрийгөө таниулах мэдрэмжийг нэмэгдүүлэх;
3. Бие махбодын болон оюуны хүртээмжтэй байдалд тэгш эрх, олон нийтийн оролцооны үзэл санааг тусгах;
4. Ирээдүйд тулгарч буй сорилтуудыг даван туулах уян хатан, тогтвортой өсөлтийг бий болгох;
5. Мөнгөнөөс илүү урлагийн үнэ цэнийг тодотгох;
6. Голландын хэвлэл мэдээллийн салбарын дэлхийн дүр төрхийг бий болгох.
7. Арилжааны болон нийтийн контент үйлдвэрлэгч, борлуулагчдын хамтын ажиллагааг идэвхжүүлж, кластер доторх огтлолцлыг нэмэгдүүлэх.

Хотын замын зураг: Алсын хараа нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгааг баталгаажуулахын тулд, Хэвлэл мэдээллийн хөгжил цэцэглэлт гэсэн нийтлэг зорилгын төлөө олон хүний дуу хоолойг нэгтгэсэн байна.

Ирээдүйн парк: Зөрчилдөөнтэй, өөр өөр зорилготой олон оролцогч, талуудтай тулгарсан тул долоо хоног бүр уулзалт зохион байгуулав. Төрөл бүрийн оролцогч талууд санаа бодлоо солилцож, Хэвлэл мэдээллийн ирээдүйн талаар санаа зовж буй зүйл, хэрэгцээгээ нээлттэй, шударгаар хуваалцахыг уриалав.

Парк ба түүний хэрэглэгчид: Нэмж дурдахад хэвлэл мэдээллийн салбарын гол удирдагчид болон нөлөө бүхий албан тушаалтнуудтай ганцаарчилсан ярилцлага хийсэн. Үүний зэрэгцээ түрээслэгчдийн жижиг бүлгүүдтэй санал бодлоо солилцох нь тус сайтын хөтөлбөр, эдийн засгийн чадавхийг нээхэд тусалсан.

Хэвлэл мэдээллийн иж бүрэн зураглал: Парк болон хүрээлэн буй орчныг хөгжүүлэх, өөрчлөх боломжтой бүс нутгийг тодорхойлох зорилгоор бүс нутгийн санхүүгийн төлөв байдалд эдийн засгийн дүн шинжилгээ хийсэн.

Амжилттай ирээдүйн төлөөх эхний алхамууд: Хилверсум Медиа Парк хотын алсын хараа нь Парк болон түүний ойр орчмын орон зайн, хөтөлбөрийн болон дэд бүтцийн ирээдүйн хөгжлийн талаархи стратегийн сэтгэлгээг танилцуулсан урьдчилсан баримт бичиг юм.

Хотын алсын хараа нь ирээдүйд өөрчлөлт хийх уян хатан тогтолцоог бий болгодог. Хилверсум хотын захиргаа болон Медиа Парк Энтерпрайз хоёр богино хугацаанд хийх эхний алхмуудыг танилцуулж байна:

1. Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, одоогийн газар эзэмшигчид, орон нутгийн төлөөллийг оролцуулах кластерийн менежментийн байгууллагыг судлах;
2. Түрээслэгчдийг төрөлжүүлэх зорилгоор Газар ашиглалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг судлах. Одоо байгаа бүсчлэлийн төлөвлөгөө нь өргөтгөх шаардлагатай орон зайг аль хэдийн хангасан тул холбогдох шинэ түрээслэгчдэд зориулсан тодорхой боломжуудыг судлах;
3. Одоогийн ачааллыг харгалзан, мөн ирээдүйн хүчин чадлыг харгалзан Медиа Парк руу нэвтрэх шинэ замуудыг судлах. Тухайлбал, шинэ зам, кабелийн автомашины холболт, галт тэрэгний давтамжийн хуваарийг судлах;
4. Оюутнуудыг цэцэрлэгт хүрээлэнд авчрах Эразмус хөтөлбөрийг эхлүүлэхийн тулд олон улсын шилдэг их дээд сургуулиудтай (жишээлбэл, Амстердамын Их Сургууль, Өмнөд Калифорнийн Их Сургууль, Лондонгийн LSE болон харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн чиглэлээр тэргүүлэгч их сургуулиуд) хамтран ажиллах;
5. Хотын алсын харааг хэрэгжүүлэх дараагийн алхмуудыг бий болгох. Тухайлбал, уян хатан бүтэц, поп-ап арга хэмжээ зохион байгуулах талбай, богино хугацаанд оршин суух зориулалтын байр, чөлөөт уран бүтээлчдийн ажлын байр, инкубаторын байгууламж гэх мэт богино хугацаанд ажиллах хөндлөнгийн оролцоог бий болгох.

2. Солонгос улс.

1990-иэд оны дунд үед Солонгосын эрх баригчид соёл, урлаг нь техникийн нэгэн адил экспортын бүтээгдэхүүн байж болох юм гэдгийг ойлгожээ. Солонгосын ерөнхийлөгч Ким Ён Сам 1994 онд найруулагч Стивен Спилбергийн “Юрийн галавын цэцэрлэг” киноны орлого Солонгосын “Хюндэй” компанийн гадаадад худалдсан 1.5 сая машины борлуулалттай тэнцүү байгааг мэдээд гайхаж биширсэндээ Соёл салбарын санхүүжилтийг эрс нэмсэн. 1990-иэд оны эхээр Солонгос улс иргэдээ гадаадад жуулчлахыг хориглосон хуулиа цуцалж солонгосчууд барууны боловсролыг эзэмших боломжтой болов. 10 орчим жил болоход орчин үеийн эдийн засаг, бизнесийн ухаанд суралцсан чадварлаг боловсон хүчин төрөн гарчээ.

Солонгос гаралтай Америкийн сэтгүүлч Юни Хонгийн бичсэнээр 1980-аад онд Солонгост урлагийн салбарт орчин үеийн урсгалыг хуулиар хорьдог байсан учраас эстрадын нэртэй дуучин, жүжигчин, одод гэхээр хүмүүс алга байв. Түүгээр ч барахгүй гудамжны дуучдыг хүртэл жагсагчид гэж үздэг байлаа. Харин 1996 онд Үндсэн хуулийн шүүхээс уг хориог цуцалснаар Солонгосын залуу үе уран бүтээлээ чөлөөтэй хийх боломж бүрджээ. Энэ шийдвэр кино, хөгжмийн урлагт хамгийн их үр дүнгээ өгсөн аж. Нобелийн шагналт Ким Дэ Жүн автомашин, ахуйн техник зэрэг экспортын уламжлалт бүтээгдэхүүн нь хямралаас хамгаалж чадахгүй гэдгийг ойлгож Засгийн газар мэдээллийн технологи, Соёл бүтээгдэхүүнийг ирээдүйн эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгосон.

Солонгосын Засгийн газрын Соёл салбарт хэрэгжүүлсэн бодлогыг “Солонгос давлагаа” (한류-халлю) гэж нэрлэдэг. Халлю гэх нэрийг Хятадын сэтгүүлчид өгсөн аж.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Соёл-эдийн засгийн энэ үзэгдэл Ази төдийгүй дэлхий нийтийг хамраад байна. 1997 оны Азийн санхүүгийн хямрал Солонгос давлагааг улам эрчимжүүлжээ. Тэр үеийн ерөнхийлөгч, Нобелийн шагналт Ким Дэ Жүн автомашин, ахуйн техник зэрэг экспортын уламжлалт бүтээгдэхүүн нь хямралаас хамгаалж чадахгүй гэдгийг ойлгож Засгийн газар мэдээллийн технологи, Соёл бүтээгдэхүүнийг ирээдүйн эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгожээ. Учир нь технологи үйлдвэрлэлийн шинэ чиглэлийг бий болгож, харин нийтийн соёл олон тэрбум ам.долларын орлого авчрах экспортын бүтээгдэхүүн болох ёстой байлаа. Засгийн газар өндөр технологийн гарааны компаниуд, поп урлагийн студиудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийх болов. 2000 он болоход Соёл экспортын орлого 500 сая, 2003 онд 650 сая, 2011 онд 4 тэрбум, хоёр жилийн дараа 5 тэрбум, 2014 онд 11.6 тэрбум ам.доллар болтлоо өсжээ.

Солонгос давлагааны гол бүтээгдэхүүн нь кино, хөгжим, олон ангит кино, компьютерын тоглоом байдаг. Поп хөгжмийн (K-pop) чиглэлд хөвгүүдийн Н.О.Т. хамтлаг 2000 онд Бээжинд тоглолт хийснээр Солонгосын поп урлаг дэлхийд тархах эхлэл болов. Солонгосын нөлөө ихсээд байсан учраас Хятадын радио, телевиз, киноны асуудал хариуцсан газраас солонгос контентын хэмжээг хязгаарлах арга хэмжээ хүртэл авч байв.

2000 оноос эхлээд Солонгосын кино Энэтхэгийн үзэгчдийг байлдан дагуулжээ. Тэр үед Agence France-Presse-д бичсэнээр Энэтхэгийн Манипур мужийн хотын гудамд залуучууд солонгос үг, хэллэг хэрэглэх нь ихэссэн байна. Удалгүй Солонгос давлагаа тэндээсээ CD, DVD болон бусад мужид тархав. 2000-аад онд K-попыг түгээгч сувгууд нь охидын Baby V.O.X., хөвгүүдийн TVXQ (2003), SS501 (2005), Super Junior (2005) хамтлагууд болов. Энэ давлагаа явсаар 2012-2013 онд PSY-гийн “Gangnam Style” дуу youtube дээр тэрбум орчим хандалт авснаар оргилдоо хүрчээ. Харин өнөөдөр хандалтын тоо бараг 3 тэрбум болоод байна. 2016 онд Forbes сэтгүүлд K-попын эдийн засагт үзүүлсэн нөлөөг үнэлэхдээ зөвхөн BIGBANG гэдэг хамтлаг сүүлийн жилүүдэд 44 сая ам.долларын орлого олсон тухай бичжээ.

Энэ нь АНУ-д хамгийн өндөр үнэлгээтэй гэгддэг “Maroon 5” хамтлагийн 33.5 сая ам.доллороос ч илүү юм. Харин Солонгосын Засгийн газар одоогоос найман жилийн өмнө Солонгос давлагааг ирээдүйд 83 тэрбум ам.доллар олох боломжтой гэж байв. Солонгос давлагааны нэгэн гол онцлог нь хэрэглэгчдээ маш сайн судалдаг (ялангуяа Азид). Засгийн газар болон Соёл асуудал хариуцсан байгууллагууд Азийн зах зээлд Соёл ямар бүтээгдэхүүн илүү амжилт олохыг байнга судалж, стратегиа баяжуулдаг. Тиймээс энэ зах зээлийг солонгосчуудаас илүү сайн мэддэг орон байхгүй гэж зарим судлаач үздэг. 1990-ид оны сүүлээс Засгийн газар төсвийнхөө нэг хувийг Соёл салбар дахь гарааны компаниудад татаас, бага хүүтэй зээл хэлбэрээр олгох болжээ. Энэ нь бусад оронтой харьцуулахад хэдэн арав дахин их юм.

Дэлхийн олон оронд Соёл бүтээгдэхүүн экспортлох тусгай төвүүд, их сургуулиудад энэ чиглэлээр тусгай тэнхим байгуулав. Зөвхөн 2016 оны эхний байдлаар Солонгосын Засгийн газар Африк, Ази-Номхон далай, Европ, Америкийн 24 оронд Солонгос давлагааг дэмжих зорилгоор 28 Соёл төв байгуулжээ. Солонгос давлагааг энэулсын “зөөлөн хүч”-ний бодлого гэж үздэг. 2012 онд УВС нэгэн сонирхолтой судалгаа хийж 2009 оноос хойш Орос, Энэтхэг, Хятад, Франц зэрэг улсад Солонгосын талаарх олон

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

нийтийн санаа бодол “бага зэрэг сөрөг” гэсэн ангиллаас “ерөнхийдөө эерэг” гэсэн ангилалд шилжсэн тухай мэдээлж байв.

3. Япон улс:

Японд бүтээлч үйлдвэрлэлийн талаар нарийн тодорхойлолт байдаггүй. Үүний оронд дизайн, гар урлалын бүтээгдэхүүн, загвар, урлаг, аялал жуулчлал, зар сурталчилгаа, хоол хүнс зэрэг амьдралын хэв маяг, соёлтой холбоотой салбаруудтай холбоотой байдаг. Бүтээлч үйлдвэрлэл нь Японы эдийн засгийн чухал хэсэг бөгөөд үүний үр дүнд засгийн газар эдгээрийг гадаадад борлуулах үйл явцад ихээхэн оролцдог.

Хүснэгт 15. Япон улсын салбаруудын тодорхойлолт:

Үйлчилгээний салбар	Зар сурталчилгаа
	Архитектур
	Тайзны урлаг
	Уран зураг
	Дизайн
	Кино
	Хөгжим
	Телевиз, радио
	Программ хангамж, компьютерын үйлчилгээ
	Хэвлэн нийтлэх
	Хувцас
Үйлдвэрлэлийн салбар	Гар урлал
	Тоглоом
	Тавилга
	Ширээний хэрэгсэл
	Үнэт эдлэл
	Бичгийн хэрэгсэл
	Арьсан эдлэл

4. Тайван:

Тайваны Сангийн яамны гаргасан мэдээллээр 2002 онд нийт Соёл бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас NT \$ 523.24 тэрбум олсон байна. Үйлдвэрлэлийн өртөг өндөртэй дөрвөн салбарыг дурдвал барилгын зураг төслийн үйлдвэрлэл, өргөн нэвтрүүлгийн үйлдвэрлэл, хэвлэлийн үйлдвэр, гар урлалын үйлдвэр байна. Аж үйлдвэрүүд дундаас хамгийн олон хүн ажилладаг нь дизайны салбар, дижитал зугаацэнгэлийн салбар, зар сурталчилгааны салбар, хэвлэлийн салбар аж үйлдвэр байна. Тайваны хамрах хүрээг авч үзвэл доорх 13 салбараар тодорхойлогдож байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Хүснэгт 16. Хамрах хүрээ

№	Салбар	Зохицуулалтын эрх мэдэл	Хамрах хүрээ
1	Дүрслэх урлагийн салбар	Соёл асуудал эрхэлсэн зөвлөл	Уран зураг, уран баримал чиглэлээр ажилладаг бүх аж ахуйн нэгжүүд болон ажилчид
2	Хөгжим ба тайзны урлагийн салбар	Соёл асуудал эрхэлсэн зөвлөл	Гүйцэтгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх аж ахуйн нэгжүүд орно.
3	Соёл үзэсгэлэнгийн салбар	Соёл асуудал эрхэлсэн зөвлөл	Менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүд орно.
4	Гар урлалын үйлдвэр	Соёл асуудал эрхэлсэн зөвлөл	Үйлдвэрлэл эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүд орно.
5	Киноны салбар	Засгийн Газрын мэдээллийн алба	Кино үйлдвэрлэдэг бүх аж ахуйн нэгжүүд
6	Өргөн нэвтрүүлгийн салбар	Засгийн Газрын мэдээллийн алба	Эдгээр үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүд орно.
7	Хэвлэлийн салбар	Засгийн Газрын мэдээллийн алба	Эдгээр хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүд орно.
8	Зар сурталчилгааны салбар	Эдийн засгийн яам	Зураг төсөл боловсруулж буй бүх аж ахуйн нэгж буюу зураг, гэрэл зураг, загварчлал, үйлдвэрлэл болон сурталчилгаа, сурталчилгааны материал суурилуулах гэх мэт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд орно.
9	Дизайн салбар	Эдийн засгийн яам	Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бүх аж ахуйн нэгжүүд орно.
10	Дизайнерын брэнд ба загварын салбар	Эдийн засгийн яам	Хувцас үйлдвэрлэдэг бүх аж ахуйн нэгжүүд орно
11	Архитектур дизайны салбар	Дотоод хэргийн яам	Архитектурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх аж ахуйн нэгжүүд орно.
12	Амьдралын хэв маягийн шинэлэг салбар	Эдийн засгийн яам	Үүнд стандартыг дагаж мөрддөг бүх аж ахуйн нэгжүүд орно. Соёл бүтээлч үйлдвэрлэл: хоол хүнс, хувцас, байр, аялал, спорт эсвэл энтертайнмент
13	Дижитал чөлөөт цаг, энтертайментийн салбар	Эдийн засгийн яам	Үйлчилгээ эрхэлж буй бүх аж ахуйн нэгжүүд орно.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Соёл бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засгийн ач холбогдол /Тайван, Их Британи, Австрали, Шинэ Зеланд, Хонконг/:

Хот	ДНБ-д эзлэх хувь	Нийт ажилтай хүн ам
Хонг Конг	2	3.7
Шинэ Зеланд	3.1	3.6
Австрали	3.3	3.7
Их Британи	7.9	4.1
Тайван	2.9	3.47

Их Британи нь ДНБ-д эзлэх хувь нь бусад хоттой харьцуулахад харьцангуй өндөр байгаа ба Тайван нь Хонг Конгтой харьцуулахад өндөр байна. (fleming, 2021)

5. Теллискиви бүтээлч хот, Таллин, Эстони:

Telliskivi Loomelinnak Creative City нь Таллин хотын хуучин хотын хажууд (ЮНЕСКОгийн Дэлхийн өвд бүртгэгдсэн) хуучин аж үйлдвэрийн цогцолборт байрладаг. 2007 онд санаачилсан Бүтээлч хот төсөл нь олон нийтэд чиглэсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хэлбэрээр төрсөн (энэ нь хувийн өмчид хэвээр бөгөөд зарим гол барилгууд нь хотын захиргаанд уртасгасан түрээсээр). Энэ нь Эстони дахь хамгийн том бүтээлч төв бөгөөд 250 компани, 1.5 мянган хүнтэй бөгөөд жил бүр тоо томшгүй олон зочдыг татдаг. Төрөл бүрийн бүтээлч үйлдвэрлэл, хэрэглээний үйл ажиллагааг хангадаг олон төрлийн үйлдвэрлэлийн орон зайтай, ажиллах талбай, бэлтгэлийн талбай, соёл урлагийн газар, Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн судалгаа 20 кафе/бар, жижиглэн худалдаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг (Ж.Эрхэмтөгс, 2019) олон төрлийн үйлчилгээг санал болгодог.

Технологи болон бүтээлч салбаруудыг холбосон, илүү уламжлалт хуучин хотоос орчин үеийн чиглэлийг бий болгож Эстонийн бүтээлч эдийн засгийн хөдөлгүүр болж чадсан юм. Үүний эхний үе шатанд бэлтгэл сургуулилтад зориулж хямд орон зай хайж буйбичил бүтээлч аж ахуйн нэгжүүд болон бие даасан Соёл байгууллагуудын илүү албан бус харилцаатай байсан. Энэ нь харьцангуй том технологи, хэвлэл мэдээллийн фирмүүд болон Фотографиска галерей зэрэг зарим "Соёл зангуу"-уудыг багтаасан жинхэнэ бүтээлч экосистем болон хувирсан.

Ерөнхийдөө энэ нь нэрийн баар, ресторан, хүнсний ачааны машин, поп-ап концепт дэлгүүр, галерей, дизайнерын жижиглэн худалдаа, студи, оффисын талбай бүхий үйлдвэрлэл, хэрэглээний эрч хүчтэй хосолсон өвөрмөц "бүтээлч газар" юм. Мөн хөгжим, кино наадам, бүүргийн зах, туршилтын театр, нийтийн урлаг зэргийг багтаасан шинэлэг Соёл хөтөлбөртэй.

Telliskivi Creative City төсөл нь хотын төвийг илүү өргөн хүрээтэй сэргээн босгох хөдөлгөгч хүч юм. Энэ нь Балтийн бүтээлч дүүрэг болж, Таллин хотын брэнд, нэр хүндийг эрс нэмэгдүүлсэн. Үндсэн үзэл баримтлал нь органик, бүтээлч энерги, бүтээлч хамт олон гэсэн ойлголт дээр суурилдаг бөгөөд үүнийг "Бүтээлч импульс, Аж үйлдвэрийн яс" гэж нэрлэдэг. Уг хөтөлбөрийн хүчирхэг баг нь үйлдвэрлэл, хэрэглээний орон зайг хангахаас гадна хүмүүсийн санаа бодлыг холбох тулгуур болж ашиглагддаг. (fleming, 2021)

6. Матадеро Мадрид, Мадрид, Испани:

Мадридын Арганзуэла дүүрэгт байрлах хуучин нядалгааны газрыг Матадеро Мадрид, орчин үеийн бүтээлийн төвийг салбар дундын урлагийн төв болгон өөрчилж олон улсын жишиг болж чадсан юм. Тус төвийг Мадрид хотын зөвлөлийн Соёл, спортын газар удирддаг бөгөөд Матадерогийн хүрээнд тус тусын бие даасан урлагийн менежментийн багуудаар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь дүрслэх урлаг, тайзны урлаг, аудио-визуал / кино, дизайн, уран зохиол, дижитал соёл, архитектур, ландшафтын уулзвар дахь бүтээлч дадлагын зэрэгцээ уран сайхны резидентурын хөтөлбөрийг бэлтгэж, танилцуулдаг. Мөн технологийн болон хэвлэл мэдээллийн компаниудтай хамтран хэрэгжүүлэх лабораторийн болон хамтран ашиглалтын төслүүдийг багтаасан бөгөөд бусад байдлаар салгагдсан нийгэмлэгүүдийг идэвхтэй холбогч үүрэг гүйцэтгэдэг байна.

Матадеро бол олон нийтийн болон бичил бүтээлч пүүсүүдийн технологи, хэвлэл мэдээллийн томоохон корпорацуудын комисс, авьяас чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаагаар холбосон орчин үеийн бүтээлч практикийн зангуу, хурдасгуур юм. "Матадеро Мадрид бол нээлтэд нээлттэй Соёл орон зай юм. Матадеро нь судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэл, боловсролыг хамарсан үйлдвэрлэлийн цикл буюу туршилтын болон нийгэмд чиглэсэн бүтээлүүдэд анхаарлаа хандуулж, урлаг, бүтээлч салбарын нийгмийн чадавхыг эрхэмлэн дээдэлдэг. Амжилтын чухал тулгуур багана нь:

- Иргэдийн оролцоо, орон нутгийн оршин суугчдад чиглэсэн хотын нийтийн эрхийн талаарх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, олон нийтийн хандлагыг бий болгодог;
- Туршилтын төслүүдийн инкубаци, судалгаа, боловсруулалт, инновацыг бий болгоход анхаардаг байна. (fleming, 2021)

7. Нант арал, Нант, Франц:

350 га талбай бүхий Нант аралд байрших уг төсөл нь чанартай Соёл бүтэц, бүтээлч ажлын талбай, ногоон байгууламж, орон сууцны талбай бүхий холимог кластер юм. Уг төсөл нь олон нийтийн оролцоотой, урт хугацааны дахин төлөвлөлтийн төсөл юм. Луара голын дунд орших нуур шиг гэх уг газар нь усан онгоц үйлдвэрлэдэг. Тус арал нь голын эрэг орчмын нөхөн сэргээлт, нийтийн орон зайг нээхэд анхаарч ажилладаг.

SAMOA нь Нант хотын лабораторийн хурдасгагч төслөөр орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллаж улмаар ЖДҮ эрхлэгчид, судлаачид, сургуулиудыг /орон зай, тоног төхөөрөмж, инженерийн хүчин чадал гэх мэт нөөцөөр хангадаг. "Уран зөгнөлт зугаа цэнгэлийн парк" гэж нэрлэгдэх үйлдвэрлэлийн төвийг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн театрын компани La Machine бүтээжээ.

Архитектур, хэрэглээний урлаг, дүрслэх урлаг, график дизайны чиглэлээр мэргэшсэн хотын урлагийн сургуулийг тус арал руу нүүлгэн шилжүүлсэн нь бүтээлч дүүрэг болж амжилтад хүрэх гол хүчин зүйл юм.

Тогтвортой арлын төлөөх тунхаг бичигт дөрвөн баримт давамгайлж байна.

- Нийтийн сайн сайхны төлөө, хамтдаа хийх соёл;
- Шинэ хөдөлгөөн (алхах, дугуй унах, нүүрстөрөгчийн саармаг шийдэл);
- Бүх иргэдийн эрүүл мэнд, сайхан байдал;
- Дасан зохицох чадвар (экологийн ул мөр, дахин ашиглах гэх мэт). (fleming, 2021)

8. Соншан соёл, бүтээлч цэцэрлэгт хүрээлэн, Тайбэй, Тайвань

2000 оны дундуур баригдаж дууссан, 1.4 га талбай бүхий Соншан Соёл Бүтээлч цэцэрлэгт хүрээлэн нь BOT (барих-ашиглах-шилжүүлэх) схемийн дагуу баригдсан өв/үйлдвэрийн барилгууд бөгөөд барилга угсралт, ашиглалт, менежментийг хагас нийтийн эзэмшилд байдаг. Хотын захиргаа 2016 онд жилийн хугацаанд Паркийн зураг төслийн тоног төхөөрөмжийн түрээсийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хамтран ажиллах станц, тэмдэглэгээний талбайг нэмж байгуулав.

Тайбэй хотын төвд байрлах томоохон бүтээлч төв болох энэхүү цэцэрлэгт хүрээлэн нь үйлдвэрлэлийн төв болон цагаан захт ажилчдын ажлын дараа уулзах газар болсон. 2013 онд цэцэрлэгт хүрээлэнгийн хажууд 1.2 га талбайд ногоон байгууламжтай, нээлттэй хаалгатай холимог зориулалттай барилга баригдсан. Холимог хэрэглээтэй энэхүү барилга нь уран бүтээлчдийн зочид буудал, томоохон номын дэлгүүр, нэрийн ресторан зэрэг туслах байгууламжийн хажуугаар ажил, тоглолт, театр, үзэсгэлэн, гадаа үйл ажиллагаа явуулах нэмэлт үйлдвэрлэл, үзэсгэлэнгийн талбайг нэмж өгсөн.

Бүтээлч аж үйлдвэрийг хөгжүүлэх хотын гол зангилаа болох Парк нь таван тэргүүлэх хөтөлбөр дээр ажилладаг.

- Бүтээлч лаборатори,
- Бүтээлч холбоо,
- Бүтээлч сургууль,
- Бүтээлч үзэсгэлэн, болон
- Бүтээлч төв.

Стратегийн гол цөм нь инноваци, авьяас чадварыг хөгжүүлэх, нийгмийн сүлжээ / хамтын ажиллагаа, брэндийн нэмүү үнэ цэнэ /сурталчилгаа, дижиталжуулалтыг байрлуулдаг. Энэ нь тухайн бүс нутгийг уялдаа холбоотой болгож, дотоод болон гадаад холболтыг нэмэгдүүлдэг. Мөн авьяас, ур чадвар, бизнесийг хөгжүүлэх, худалдаа нь газар зохион байгуулалттай холбогддог бөгөөд энэ паркийг бүтээлч эдийн засгийн гол зангилаа, хөдөлгөгч болгоход үүрэг гүйцэтгэдэг.

Тус цэцэрлэгт хүрээлэн нь Тайбэй метро даяар төвлөрсөн бүтээлч фирмүүдийн уулзах цэг болсон бөгөөд энэ нь эргээд кампус дахь инноваци, бүтээмжийг нэмэгдүүлдэг. Өв соёл нь цэцэрлэгт хүрээлэнд өвөрмөц өнгө төрх, мэдрэмжийг төрүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх буюу иргэдийн тарьж ургуулсан брэндүүдийг үндэс болгон үзэмжийг нэмэгдүүлсэн байна. (fleming, 2021)



2. ТӨСЛИЙН ХЭСЭГ

1. Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын хөрөнгө оруулалтын ашигтай загварыг тодорхойлно.
2. Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын удирдлагын зүй зохистой, үр дүнтэй системийг тодорхойлно.
3. Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын нийт хэмжээ, хүчин чадлын тооцоог тодорхойлно.
4. Соёл бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборт байрших объектуудыг тодорхойлж, байршлын ерөнхий схем боловсруулна.

БҮЛЭГ 6. ЦОГЦОЛБОРЫН ХЭМЖЭЭНД ГАРАХ АЖЛЫН БАЙРНЫ ТООНЫ ТӨСӨӨЛӨЛ

Соёл бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлалын цогцолборын хэмжээнд ирээдүйд бий болох ажлын байрны тоог тооцохын тулд Монгол Улсын хүн амын өсөлт түүнээс ажиллах хүчин болоод эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажил эрхлээгүй иргэд, ажилгүйдлийн түвшин зэргийг судалж, анализ хийх шаардлагатай тул дараах тооцооллуудыг хийв.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан Хүн амын 2015-2045 оны хэтийн шинэчилсэн тооцоонд үндэслэн хөдөлмөрийн насны хүн амыг тооцож, нийт хөдөлмөрийн насны хүн амын хувьд ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар 58 хувьтай байгаа бөгөөд үүнийг үндэслэн эдийн засгийн идэвхтэй хүн амыг тооцов.

“Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч буюу хөдөлмөрийн насны хүн ам)”-д Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Хүснэгт 17. Монгол Улсын харьяат хөдөлмөрийн насны хүн ам 2015 - 2045 он /1000 хүн ам/

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Нийт хүн ам*	3057.8	3119.9	3177.9	3238.5	3296.9	3357.5	3417.1	3479.9	3541.8	3602.5
Хөдөлмөрийн насны хүн ам**	2022.9	2107.0	2220.4	2226.6	2106.0	2128.1	2349.4	2392.6	2435.1	2476.9
ЭЗИХА**	1243.9	1275.6	1357.4	1358.6	1273.9	1250.6	1444.7	1471.2	1497.4	1523.1

	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034
Нийт хүн ам*	3662.2	3720.9	3778.9	3836.2	3893.2	3950.1	4007.2	4064.9	4123.6	4183.9
Хөдөлмөрийн насны хүн ам**	2517.9	2558.3	2598.1	2637.6	2676.7	2715.8	2755.1	2794.8	2835.2	2876.6
ЭЗИХА**	1548.3	1573.1	1597.6	1621.9	1645.9	1670.0	1694.1	1718.6	1743.4	1768.8

	2035	2036	2037	2038	2039	2040	2041	2042	2043	2044	2045
Нийт хүн ам*	4246.2	4310.8	4378.1	4448.3	4521.1	4596.5	4674.7	4755.5	4838.8	4923.9	5010.3
Хөдөлмөрийн насны хүн ам**	2919.4	2963.9	3010.2	3058.4	3108.4	3160.3	3214.1	3269.6	3326.9	3385.3	3444.8
ЭЗИХА**	1795.2	1822.5	1851.0	1880.6	1911.4	1943.3	1976.4	2010.5	2045.7	2081.7	2118.2

Эх сурвалж: * - Үндэсний статистикийн хороо, ** - Судлаачийн тооцоолол

Хөдөлмөрийн насны хүн ам 2015 - 2018 онуудад дунджаар 54.4 мянган хүн амаар нэмэгдсэн бол эдийн засгийн идэвхтэй хүн ам мөн тус онуудад 33.5 мянган хүн амаар нэмэгдсэн ч 2019, 2020 онуудад “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр 6.2 хувь болон 4.5 хувиар тус тус буурсан байна. 2021-2045 онуудад нийт хүн амын өсөлт болон эдийн засгийн төсөөллөөс харахад цаашид хөдөлмөрийн насны хүн ам болон эдийн засгийн идэвхтэй хүн ам өсөх хандлагатай байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

2045 он хүртэлх хүн амын тоог тооцсон тооцооллоос харахад Монгол Улсын харьяат хүн ам, хөдөлмөрийн насны хүн амын тоо, эдийн засгийн идэвхтэй ажиллах хүчин өсөхөөр байна. Энэ нь хөдөлмөрийн нийлүүлэлт нэмэгдэх бүрт улс оронд ажлын байр өөрөөр хэлбэл хөдөлмөрийн эрэлт нэмэгдэх шаардлагатай гэсэн үг юм.

Хүснэгт 18. ЭЗИХА, ажил эрхэлж буй болон ажил эрхлээгүй иргэдийн тоо, 2010 он - 2021 он, 1000 хүн ам

	2010	2011	2012	2013	2014	2015
ЭЗИХА	1147.2	1124.7	1151.2	1198.3	1206.6	1243.9
Ажил эрхэлж буй иргэд	1033.7	1037.7	1056.4	1103.6	1110.7	1151.2
Ажил эрхлээгүй иргэд	113.4	87.0	94.7	94.7	95.9	92.7

	2016	2017	2018	2019	2020	2021
ЭЗИХА	1275.6	1357.4	1358.7	1273.9	1250.6	1226.5
Ажил эрхэлж буй иргэд	1147.8	1238.3	1253.0	1146.2	1162.9	1127.1
Ажил эрхлээгүй иргэд	127.8	119.1	105.6	127.7	87.7	99.4

Дээр тооцсон эдийн засгийн идэвхтэй хүн амд үндэслэн 2045 он хүртэлх ажиллагчдын болон ажил эрхлээгүй иргэдийн тоог таамагласныг дараах хүснэгтэд харуулж байна.

Хүснэгт 19. ЭЗИХА, ажил эрхэлж буй болон ажил эрхлээгүй иргэдийн тооны таамаглал 2022 он - 2045 он, 1000 хүн ам

	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031
ЭЗИХА	1471.2	1,497.4	1,523.1	1,548.3	1573.1	1597.6	1,621.9	1,645.9	1,670.0	1,694.1
Ажил эрхэлж буй иргэд	1344.7	1368.6	1392.1	1415.1	1437.8	1460.2	1482.4	1504.4	1526.4	1548.4
Ажил эрхлээгүй иргэд	126.5	128.8	131.0	133.2	135.3	137.4	139.5	141.6	143.6	145.7


	2032	2033	2034	2035	2036	2037	2038	2039	2040	2041
ЭЗИХА	1,718.6	1,743.4	1,768.8	1,795.2	1,822.5	1,851.0	1880.6	1911.4	1943.3	1976.4
Ажил эрхэлж буй иргэд	1570.8	1593.4	1616.7	1640.8	1665.8	1691.8	1718.9	1747.0	1776.2	1806.4
Ажил эрхлээгүй иргэд	147.8	149.9	152.1	154.4	156.7	159.2	161.7	164.4	167.1	170.0

	2042	2043	2044	2045
ЭЗИХА	2010.5	2045.7	2081.7	2118.2
Ажил эрхэлж буй иргэд	1837.6	1869.8	1902.7	1936.1
Ажил эрхлээгүй иргэд	172.9	175.9	179.0	182.2

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Зураг 6. Ажил эрхэлж буй иргэд болон ажилгүй иргэдийн тоо 2022 - 2045 он



Эх сурвалж. Судлаачийн тооцоолол

2010 - 2021 онуудад нийт ажиллагчдын тоонд Соёл, урлагийн салбарт ажиллагчдын эзлэх хувь дунджаар 0.61% байгаа ба тус салбарт ажиллагчдын тоо жилд дунджаар 1.28 хувийн өсөлттэй байв.

Энэ тоонд мэргэжлийн урлагийн байгууллага, Соёл төв (ордон), кино театр, суурин кино цэг, нүүдлийн кино цэг, музей, номын сан зэрэг төсөвт байгууллагад ажиллажбайгаа хүмүүсийг оруулсан болно.

Хүснэгт 20. Соёл салбарт ажиллагчдын тоо, 2010 он - 2021 он

	2010	2011	2012	2013	2014	2015
Нийт ажиллагчдын тоо, мян.хүн	1033.7	1037.7	1056.4	1103.6	1110.7	1151.2
Соёлын салбарын ажиллагчдын тоо, хүн	6233	6457	6845	7011	6813	6783
Эзлэх хувь, %	0.60%	0.62%	0.65%	0.64%	0.61%	0.59%
Өсөлт, бууралт, %	-	3.59%	6.01%	2.43%	- 2.82%	- 0.44%

	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт ажиллагчдын тоо, мян.хүн	1147.8	1238.3	1253.0	1146.2	1162.9	1127.1
Соёлын салбарын ажиллагчдын тоо, хүн	7140	7005	7041	7202	7318	7140
Эзлэх хувь, %	0.62%	0.57%	0.56%	0.63%	0.63%	0.63%
Өсөлт, бууралт, %	5.26%	-1.89%	0.51%	2.29%	1.61%	-2.43%

Эх сурвалж. Үндэсний статистикийн хороо

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Цаашид бодлогоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй өсөлт энэ хэвээр хадгалагдана гэж үзвэл 2045 он гэхэд 11810 хүн энэ салбарт, үүнээс 2244 хүн нийслэлд ажиллахаар байна.

Хүснэгт 21. Соёл салбарт ажиллагчдын тооны таамаглал, 2022 он - 2045 он

	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Нийт ажиллагчдын тоо, мян.хүн	1344.7	1368.6	1392.1	1415.1	1437.8	1460.2	1482.4	1504.4	1526.4
Соёлын салбарын ажиллагчдын тоо, хүн	8203	8348	8492	8632	8771	8907	9043	9177	9311
Үүнээс: нийслэлд ажиллагчдын тоо, хүн	1559	1586	1613	1640	1666	1692	1718	1744	1769

	2031	2032	2033	2034	2035	2036	2037	2038	2039
Нийт ажиллагчдын тоо, мян.хүн	1548.4	1570.8	1593.4	1616.7	1640.8	1665.8	1691.8	1718.9	1747.0
Соёлын салбарын ажиллагчдын тоо, хүн	9445	9582	9720	9862	10009	10161	10320	10485	10657
Үүнээс: нийслэлд ажиллагчдын тоо, хүн	1795	1821	1847	1874	1902	1931	1961	1992	2025

	2040	2041	2042	2043	2044	2045
Нийт ажиллагчдын тоо, мян.хүн	1776.2	1806.4	1837.6	1869.8	1902.7	1936.1
Соёлын салбарын ажиллагчдын тоо, хүн	10835	11019	11209	11406	11606	11810
Үүнээс: нийслэлд ажиллагчдын тоо, хүн	2059	2094	2130	2167	2205	2244

Эх сурвалж. Судлаачийн тооцоолол

Дээрх статистик тоонд хувийн хэвшлийн соёл, урлагийн ажиллагчид, чөлөөт уран бүтээлчдийн тоо, Соёл бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарын үйл ажиллагааг дэмжсэн тоног төхөөрөмж, дагалдах материалын болон нийтлэг хамааралтай салбарын ажиллагчдын тоо ороогүй юм.

2021 онд Соёл яамны хийсэн “Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа”-ны номд 2020 оны байдлаар Соёл бүтээлч үйлдвэрлэлийн салбарт нийт 74871, үүнээс Соёл салбарт 33931, тоног төхөөрөмж, дагалдах материалын салбарт 26732, нийтлэг хамааралтай салбарт 12872, холбогдох (аялал жуулчлал, спорт чөлөөт цаг) салбарт 1337 хүн ажилладаг гэжээ. Мөн эдгээр салбаруудаар мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалтын төвүүдийг жил бүр 3000 гаруй оюутан төгсөж байгааг мэргэжлийн хөтөлбөр тус бүрээр гаргасан байна.

Эндээс, Соёл салбарын статистикийн системийг боловсронгуй болгон сайжруулах, “Соёл статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна. Мөн Соёл бүтээлч үйлдвэрлэл нь ийн салбарын үзүүлэлтүүдийг нэг бүлэг болгон нэмж оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа

Цогцолборын хэмжээнд шинээр бий болох боломжит ажлын байрны тоог барилга угсралтын үе шатанд бий болох ажлын байр, ашиглалтад орсноос хойш гарах байнгын ажлын байр, дагалдан бий болох дам ажлын байр гэсэн ангиллаар дараах байдлаар тодорхойлоод байна.

Хүснэгт 22. Цогцолборын хэмжээнд бий болох ажлын байрны тоо

№		Шууд ба шууд бус ажлын байрны тоо
Ашиглалтад орсны дараах байнгын ажлын байр		
Бүс 1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор		
	Кино үйлдвэрлэлийн хотхон	1100
	Дизайн урлагийн хотхон	1250
	Судалгаа, хөгжүүлэлтийн хотхон	2500
	Монгол ёс заншил, өв уламжлал, үндэсний үнэт зүйл, Соёл хотхон	400
	Тайзны урлаг, хөгжмийн хотхон	500
	Контент үйлдвэрлэлийн хотхон	1000
Цогцолборын хэмжээнд бий болох ажлын байр		
	Спорт, эрүүл мэнд, чөлөөт цагийн үйлчилгээ хариуцсан	150
	СБҮ-ийн цогцолборын дэд бүтэц, тохижилт үйлчилгээ, хэвийн ажиллагаа хариуцсан	350
	Дэлгүүр, цайны газар, ресторан, кофе шоп г.м. олон нийтийн үйлчилгээ хариуцсан	250
	Цогцолборын аюулгүй байдал, аврах анги /гал унтраах, харуул хамгаалалт г.м./	100
	Бүс 1. Нийт тоо	7600
Бүс 2. Аялал жуулчлалын цогцолбор		
	Миний Монгол цогцолбор /нийтийн үйлчилгээний ажилтнууд г.м./	300
